

## **ГОВЬСУМБЭР АЙМГИЙН АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**


**Нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын амьтдын ашиглалт, хамгааллын менежмент төлөвлөгөө, агнуурын зүйлийн популяцийн үнэлгээ, амьдрах орчны хамгаалал**


**Захиалагч: “Байгаль орчин, аялал жуулчлалын газар”**

**Гүйцэтгэгч: “Агнуур Судлалын Нийгэмлэг” ТББ**



**Улаанбаатар хот  
2019 он**

БАТЛАВ. БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙН  
УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА   
П. ЦОГТСАЙХАН



## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Танилцаж, зөвшөөрсөн:

БОАЖЯ-НЫ Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын  
газрын мэргэжилтэн:  В.НОМИН-ЭРДЭНЭ

Боловсруулсан:

Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллага  
“Агнуур судлалын нийгэмлэг” ТББ-ын

Тэргүүн:  Э.Магсаржав



Улаанбаатар хот

2019

**ГОВЬСУМБЭР АЙМГИЙН АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

**ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:**

ГОВЬСУМБЭР АЙМГИЙН БОАЖГЫН ДАРГА ..... Д.МӨНХ-ЭРДЭНЭ



ГОВЬСУМБЭР АЙМГИЙН БОАЖГЫН АМЬТНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН ..... Т.ДАШЦЭДЭН

**Улаанбаатар хот**

**2019**

## ГАРЧИГ

## ОРШИЛ .....

3

1.1. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ .....	4
1.1.1. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ҮНДЭСЛЭЛ.....	4
1.1.2. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ.....	4
1.2. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН АРГАЧЛАЛЫН ТОЙМ ...	5
1.3. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГ .....	7
1.4. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ, ЦАГ УУРЫН ОНЦЛОГ .....	9
1.5. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АМЬТНЫ АЙМГИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ, АМЬТДЫН АМЬДРАХ ОРЧНЫ ОНЦЛОГ .....	10
1.6. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УРГАМЛЫН АЙМГИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ .....	13
1.7. АРГАЛЬ ХОНИНЫ БИОЛОГИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ .....	14
1.8. СААРАЛ ЧОНЫН БИОЛОГИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ .....	21
1.9. ЦАГААН ЗЭЭРИЙН БИОЛОГИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ .....	24
1.10. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН “СҮМБЭР” СУМЫН АРГАЛЬ ХОНИНЫ БАЙРШИЛ, БИОЛОГИЙН НӨӨЦ, СҮРГИЙН БҮТЭЦ .....	27
1.11. СҮМБЭР СУМЫН “ХАЛЗАН УХАА” АБН-Н ЦАГААН ЗЭЭРИЙН БАЙРШИЛ, БИОЛОГИЙН БОЛОН АГНУУРЫН НӨӨЦ, СҮРГИЙН БҮТЭЦ .....	30
1.12. БАЯНТАЛ СУМЫН “ХАЛЗАН “БАЯН” АБН-Н ЦАГААН ЗЭЭРИЙН БАЙРШИЛ, БИОЛОГИЙН БОЛОН АГНУУРЫН НӨӨЦ, СҮРГИЙН БҮТЭЦ .....	32
<b>ХОЁРДУГААР БҮЛЭГ. АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ЗАРЧИМ АЧ ХОЛБОГДОЛ .....</b>	<b>39</b>
2.1. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХАМГААЛЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТҮҮНД ТУЛГАРЧ БҮЙ БЭРХШЭЭЛ .....	39
2.2. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ .....	42
2.3. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ОНЦЛОГ, АЧ ХОЛБОГДОЛ .....	43
<b>ГУРАВДУГААР БҮЛЭГ. МЕНЕЖМЕНТИЙН БҮТЭЦ, САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР, ЗОРИЛГО, ЗОРИЛТ, СТРАТЕГИ УЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ .....</b>	<b>44</b>
3.1. АН АМЬТНЫ МЕНЕЖМЕНТИЙН БҮТЭЦ, САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР .....	44
3.2. САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР БА ДУНДЫН САН ХУРИМТЛАЛ .....	45
3.3. АГНУУРЫН БУС НУТГИЙН МЕНЕЖМЕНТЭД ОРОЛЦОГЧ ТАЛУУД .....	45
3.4. ХАМГААЛАХААР СОНГОСОН АМЬТНЫ ЗҮЙЛД УЧИРЧ БҮЙ АЮУЛ ДАРАМТ .	45
3.5. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД.....	46
3.6. ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ/ СТРАТЕГИ.....	48

3.7. 2019-2023 СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ .....	49
ДӨРӨВДҮГЭЭРБҮЛЭГ.МЕНЭЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ, МОНИТОРИНГ .....	55
4.1. АМЬТНЫГ ХАМГААЛАХ, НӨӨЦИЙГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН БҮТЭЦ.....	55
4.2. ОРОН НУТГИЙН ИРГЭДЭД ТУШИГЛЭСЭН АГНУУРЫН МЕНЭЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ.....	56
4.3. ҮНЭЛГЭЭ, МОНITORИНГ .....	58
<b>ХАВСРАЛТУУД НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР .....</b>	<b>59</b>

**ЗУРАГ, ДИАГРАММ, ХУСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 5-р багийн иргэдэд хийсэн зэрлэг амьтны хамгаалал ба бэлчээрийн менежментийн сургалт, 2019-10-06.....	7
Зураг 2. “Сүмбэр” үүлдэрийн хонь .....	8
Зураг 3. Ус намгийн шувууд Хаялга нуур 7-р сар .....	11
Зураг 4. Хурын ногооны тойром зэгсэнд зарим нүүдлийн шувууд үрждэг.....	11
Зураг 5. Чойрын Богд уул, 2019 оны 9-р сар .....	12
Зураг 7. Говьсүмбэр аймаг Сүмбэр сум аргаль хонини сүрэг .....	28
Зураг 8. Цагаан зээрийн сүрэг. Говьсүмбэр аймаг Сүмбэр сумын нутаа.....	34
Зураг 9. Монгол тарвага Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум Чойрын богд уул.....	35
Зураг 10 Идлэг шонхор Говьсүмбэр аймаг Сүмбэр сум .....	37
Зураг 11 Чойрын богд ууланд бидний судалгаагаар б толгой саарал чоно байгаа тогтоов.....	38

**ДИАГРАММ**

Диаграмм 2. Аргаль хонини сүргийн бүтэц.....	29
Диаграмм 3. Угалз, хомийн харьцаа.....	29
Диаграмм 4. Аргаль хонини нөхөн үржлийн чадавхи.....	29
Диаграмм 5 “Халzan ухаа” агнуурын бүс нутгийн цагаан зээрийн сүргийн бүтэц .....	31
Диаграмм 6. Хүйсийн харьцаа .....	31
Диаграмм 7. Цагаан зээрийн нөхөн төлжилтийн чадавхи .....	31
Диаграмм 8. “Баян” агнуурын бүс нутгийн цагаан зээрийн сүргийн бүтэц.....	33
Диаграмм 9. Хүйсийн харьцаа .....	33
Диаграмм 10. Цагаан зээрийн нөхөн төлжилтийн чадавхи .....	33

## ОРШИЛ

Зэрлэг ан амьтан бол Монгол орны үнэт баялаг. Өөрөө өөрийгөө нөхөн төлжүүлж байдаг энэхүү баялгийг зөв зохистой ашиглах аваас улс орны эдийн засагт баагүй хувь нэмэр оруулах нэгэн эх сурвалж юм. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн, байгальд ээлтэй зохистой ашиглалт гэдэг нь, тухайн салбарын мэдлэгт тулгуурлан чухам юу болохыг оновчтой тодорхойлох, эрх зүйн орчинг хангах, хэрэгжилтийг хангахуйц амьдрах чадвартай бүтэц бий болгох, мэргэжлийн оролцоог хүртээлтэй болгох зэрэг олон асуудлуудыг шийдвэрлэсний үр дүнд хэрэгжинэ.

Ан амьтныг хамгаалахын зэрэгцээ түүний нөөцийг зөв зохистой ашиглах нь тогтвортой хөгжлийн нэг зорилт болохыг манай орны нэгдэн орсон, одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдэж байгаа олон улсын холбогдох конвенц, байгаль хамгаалал, ан амьтан хамгаалах чиглэлийн нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудын үзэл баримтлал, зарчим, дүрэм, журам ч баттай гэрчилж байна. Одоогоор байгаль хамгааллын салбарын анхаарлаас хөндий орхигдсон нэг асуудал бол ан амьтны нөөцийг зохистой ашиглах ажлыг улсын хэмжээнд оновчтой арга хэлбэрээр зохион байгуулах, хэрэгжүүлэх ажил юм. Байнга нөхөн төлждөг баялагийг зохистой ашигласнаар түүнээс олох ашиг орлого тогтворжиж, улс орны эдийн засгийн эргэлтэнд зохих хувь нэмэр болохын зэрэгцээ ан амьтны хамгаалал сайжирах боломжтой. Зохистой ашиглалт бол байгаль хамгаалах нэг арга хэрэгсэл болохыг дэлхий дахинаа хүлээн зөвшөөрсөн цаг үед бид амьдарч байна. Дээрх арга хэмжээг ан агнуурын менежментийн төлөвлөгөөгүйгээр явуулах бололцоогүй билээ. Иймээс Говьсүмбэр аймгийн агнуурын зүйлүүдийг хамгаалах менежментийн төлөвлөгөө боловсруулах шаардлага урган гарч байна. Энэхүү менежментийн төлөвлөгөөнд иргэдийн оролцоог зохистой хэлбэрээр хангах, учирч буй аюул дарамтыг бууруулж, хамгаалах, агнуурын нөөцийг тогтвортой ашиглах талаарх арга хэмжээг тусгасан. Уг төлөвлөгөөг боловсруулахдаа агнуурын зүйлүүдийн биологийн нөөц, сүргийн бүтэц, өсөн үржих чадавх, амьдрах орчин, хамгааллын одоогийн байдал, түүнд учирч буй бэрхшээл, эрсдэлийг нь тогтоосон үнэлгээг үндэс болгов.

Энэхүү менежментийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлснээр агнуурын зүйлүүдийн хамгаалал, ашиглалтанд тулгамдаж буй асуудлуудлыг шийдвэрлэж, төр, иргэд, хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлж, байгаль хамгаалах зорилго зорилтуудыг хамтран үр дүнтэй шийдвэрлэх боломж олгох, нутгийн иргэдэд түшиглэсэн, хамтын байгалийн нөөцийн менежментийг хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын төр, Засгийн газраас агнуурын санг хамгаалах, зохистой ашиглах талаар баримталж буй бодлого, дэлхий нийтийн жишиг, чиг хандлагад тулгуурласны зэрэгцээ ерөнхий агнуур зохион байгуулалтын тайланд тулгуурлав.

Менежментийн төлөвлөгөө нь 2019-2023 онуудад хэрэгжих бөгөөд үндсэн, зарчим, аргачлал, онцлог, хамгаалалтын өнөөгийн байдал байгаль, цаг уурын нөхцөл, учирч буй бэрхшээл, эрсдлүүдэд хийсэн үнэлгээ, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тус тус багтаасан болно. Говьсүмбэр аймгийн БОАЖГазар, нутгийн иргэдийн нөхөрлөл, аймаг, сумын удирдлагуудын идэвхтэй оролцоотойгоор ан амьтны мэргэжлийн байгууллага “Агнуур судлалын нийгэмлэг” ТББ, менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

1.1. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

1.1.1. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ҮНДЭСЛЭЛ

Аливаа үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлт нь тухайн үйл ажиллагааг хэрхэн төлөвлөсөнтэй шууд холбоотой байдаг. Тийм ч учраас байгаль орчин, байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах зорилгоор боловсруулсан төлөвлөлт нь тухайн байгалийн нөөц, баялагт хүний үйл ажиллагаанаас одоо болон ирээдүйд гарч болзошгүй бууруулах зөв арга замыг хайх замаар боловсруулдаг. Гарч байгаа сөрөг нөлөөллийн учир шалтгааныг буруу тогтоох, орхигдуулснаас, зөв оновчтой үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлж чадахгүйд хүрнэ. Тиймээс хүсэн хүлээж буй үр дүндээ хүрэхийн тулд урт хугацаанд олон талаас нь хэлэлцэж сайн төлөвлөлтийг хийх нь зүйтэй байдаг.

Монгол Улсын хөдөөгийн хүн амын амьжиргааны эх үүсвэр нь бэлчээрийн мал аж ахуй бөгөөд мал, зэрлэг амьтан, ургамлын бүлгэмдэл нь ус, бэлчээрийн төлөв байдлаас шууд хамааралтайгаар өсөн үрждэг билээ. Гэтэл сүүлийн хорь гаруй жилд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагааны нөлөөлөл /цөлжилт, ган зуд, усны хомсдол, бэлчээрийн талхагдал/ нь нийт нутгийг хамрах боллоо. Энэ нь бэлчээрт суурилсан мал аж ахуй, түүнтэй зэрэгцэн оршин тогтносоор ирсэн зэрлэг амьтдын хувьд эрсдэлд орох бодит аюул нүүрлэж байна. Мөн агнуурын амьтдын ашиглалт нь хэт эмх замбараагүй, оновчгүй хувиарлалт зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан зарим зүйл боловсруулах гол үндэслэл боллоо.

1.1.2. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар шинэчлэн батлагдсан “Амьтны тухай хууль”-д хэд хэдэн шинэ үзэл баримтлалыг тусгасан байдаг. Тухайлбал, Амьтны тухай хуулийн 4.1.11 дэх заалтад тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бус нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үргүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичиг нь “ан агнуурын менежментийн төлөвлөгөө” байна гэж тусгасан байна.

“Амьтны тухай хууль”-ийн 5.3.2; 5.8.3; 21.4.1; 21.5.3; 22.3; 22.6; 23.1 дэх заалтад ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулан, батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих, ан агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу агнуурын бус нутгийг тогтоож, түүний тодорхой хэсгийг эзэмшүүлэх гэх мэт үйл ажиллагааны зохицуулалт тусгагдсан байдаг.

Ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд суурилсан хамгаалал, зохистой ашиглалтыг хэрэгжүүлэх зорилгоор 2013 онд Засгийн газрын 93 дугаар тогтоолоор батлагдсан “Ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох тухай журам”-ын 6.1-д хариуцаж буй агнуурын бус нутгийн нарийвчилсан агнуур зохион байгуулалтыг

мэргэжлийн байгууллагаар хийлгэж, ан агнуурын менежментийн төлөвлөгөөг батлуулсан байхаар тусгасан байна.

Засгийн газрын 2013 оны 93 дугаар тогтоолоор батлагдсан “Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын ажиллах журам”-ын 1.3-т тухайн агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч иргэн, хуулийн этгээд нь ан агнуурын менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлнэ гэж тусгажээ.


Иймд, “Амьтны тухай хууль”-ийн 21.4.1, 21.5.3 дахь заалт, Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 07 дугаар тогтоолоор батлагдсан “Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын ажиллах журам”-ын 1.3, “Ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох тухай журам”-ын 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн Говьсүмбэр аймгийн ан агнуурын менежмент төлөвлөгөөг, ерөнхий агнуур зохион байгуулалт, Байгаль хамгаалагчдын хэлэлцүүлэг, сумын байгаль орчны байцаагч, Засаг дарга нарын уулзалтын үр дүнд тулгуурлан боловсрууллаа.

## **1.2. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН АРГАЧЛАЛЫН ТОЙМ**

Говьсүмбэр аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг Америкийн нэгдсэн улсын Де Нэйчэ Консерванси төрийн бүс байгууллагын боловсруулсан САР буюу Байгаль хамгааллын үйл ажиллагааны тасралтгүй үргэлжлэх, давтагдах, сайжруулах үйл явцыг агуулсан процесс бүхий төлөвлөлт боловсруулдаг арга зүйг ашиглан боловсруулав. Учир нь агнуурын бүс нутгийн зөвхөн агнуурын амьтныг хамгаалах, зохистой ашиглах асуудал гэж хязгаарлаагүй харин тухайн агнуурын амьтан нь тухайн экосистемийн үйл явцын нэг бүрэлдэхүүн учраас агнуурын бүс нутгийн байгалийн нөөцийн менежмент гэсэн агуулгыг багтаасан болно.

Агнуурын бүс нутаг дахь биологийн олон янз байдлыг тогтвортой байлгахад зорилтот буюу зайлшгүй хамгаалах амьтан, ургамал, эко системийг сонгон зорилго дэвшүүлсэн. Мөн сонгосон амьтан, ургамал, экосистемд одоо болон ирээдүйд тулгарч буй аюул, дарамтыг олж тодорхойлох, түүн дээр түшиглэн зорилт боловсруулах, үйл ажиллагааг төлөвлөж хэрэгжүүлэх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа дүгнэх/хэмжих энэ бүгдээс суралцаж дахин асуудлыг тодорхойлох, төлөвлөх гэх мэтээр үргэлжлэх тасралтгүй процесс гэж ойлгоно. (Схем-1)

Схем 1. Байгаль хамгааллын үйл ажиллагаа



Бид Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 5-р багийн иргэдэд 2019 оны 10-р сарын 6-нд 50 гаруй өрхийн малчдад зэрлэг амьтан хамгаалал, бэлчээрийн өнөөгийн төлөв байдлын тухай сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.



Зураг 1. Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 5-р багийн иргэдэд хийсэн зэрлэг амьтны хамгаалал ба бэлчээрийн менежментийн сургалт, 2019-10-06.

### 1.3. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГ

Энэхүү танилцуулгаар Говьсүмбэр аймгийн хөдөө аж ахуйн салбарын үзүүлэлтүүд ялангуяа мал аж ахуй, газар тариалангийн хөгжил суулийн жилүүдийн мэдээллийг орууллаа. Хөдөө аж ахуйн салбар нь мал аж ахуй, газар тариалан гэсэн хоёр дэд салбараас бүрддэг байна.

Хөдөө аж ахуйн нийт үйлдвэрлэлийн хэмжээг жилийн туршид мал, амьтдыг өсгөн үржүүлсний болон ургамал, тариа, хүнсний ногоо тарьж ургуулсны дүнд бий болсон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өртгийн нийлбэр дүнгээр тодорхойлдог.


Говьсүмбэр аймгийн нийт малын улсад эзлэх хувь тайлант онд өмнөх оноос 0.1 пунктээр, төвийн бүсийн малын тоонд эзлэх хувь өмнөх оноос 0.02 пунктээр тус тус буурсан байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар Говьсүмбэр аймаг 427460 толгой мал тоолуулснаас:

- Адуу 20591 толгой
- Үхэр 14004 толгой
- Тэмээ 1064 толгой

- Хонь 208084 толгой
- Ямаа 183717 толгой тоологдоо.

Нийт малын 4.8 хувийг адуу, 3.3 хувийг үхэр, 0.2 хувийг тэмээ, 48.7 хувийг хонь, 43.0 хувийг ямаа эзэлж байна.



**Зураг 2. "Сүмбэр" үүлдэрийн хонь**

Каракуль үүлдрийн хонь нь маш эрт үеэс дундад Азийн малчдын уйгагүй хөдөлмөр болох шилэлт сонголтын ажлыг чадамгай явуулсны үр дүнд бий болсон байна. 1900 оноос өмнө каракуль үүлдрийн хонийг үржүүлж байсан цорын ганц орон нь Зөвлөлт холбоот улс / Узбекистан болон Туркмен /байсан бөгөөд тухайн үеийн тооллогоор 4 сая гаруй каракуль үүлдрийн хонь тоологдож байжээ. 1928 онд анхны каракулийн аж ахуй нь "Мубарек" нэртэйгээр Узбекистанд байгуулагдсан бол Монгол улс 1956 онд ЗХУ-ын Узбек ССР-ийн Самарканд мужийн "Улус" нэртэй аж ахуйгаас 11 хуц, 17 эм хонь авчирч тэр жилдээ 3837 монгол хонийг каракуль хуцаар хээлтүүлэн хавар нь 1644 эрлийз төл хүлээн авснаар каракуль хонь үржүүлэх эхлэл тавигдсан байна.

Каракуль хонийг анх Увс, Өвөрхангай, Төв, Дорноговь, Өмнөговь, Баянхонгор аймгийн сумдад үржүүлж байсан бөгөөд Каракуль хонины нутагшилтыг судалснаар 1970 онд Намын төв хороо, Сайд нарын Зөвлөлийн 79, 196 дугаар тогтоолоор Төв аймгийн Архуст сангийн аж ахуй болон Увс аймгийн Баруунтурууны сангийн аж ахуйд үржүүлж байсан каракуль хонийг манай орны тал хээрийн бүсэд орших Дорноговь аймгийн Сүмбэр сум буюу одоогийн Говьсүмбэр аймгийн Сүмбэр суманд шилжүүлэн сууришуулж, каракуль үржүүлж байгаа бусад газруудыг үржлийн материалаар хангаж байх улсын үржлийн аж ахуй болгон зохион байгуулан улсын төсвөөр санхүүжүүлж байлаа. 1974-1976 онуудад каракуль хонины тоо толгой хамгийн их буюу 73.0-78.0 мянган толгойд хүрч, 1991-1993 онуудад хамгийн их буюу 11.0-23.0 мянган ширхэг арьс бэлтгэж байсныг хүснэгтээс харж болно. Каракуль үүлдрийн хонины аж ахуйг аж ахуйн зохион байгуулалтын талаар бэхжүүлэх болон материаллаг баазаар хангах тал дээр томоохон арга хэмжээ авч ажилласны үр дүнд 1983 оны байдлаар улсын хэмжээнд цэвэр үүлдрийн каракуль 4500, эрлийз каракуль 100 орчим мянган толгойд хүрч, 30 мянган ширхэг арьс бэлтгэн, 205 гаруй тонн ноос, 8000 орчим ходоод болон бусад бүтээгдэхүүнийг бэлтгэн ашиглаж байснаас Дорноговь аймгийн Сүмбэр сумын Каракулийн аж ахуй нь тухайн онд цэвэр каракуль хонь 4336 толгой, өндөр үеийн эрлийз каракуль 54 мянган толгойг тоолуулж, 20 мянга орчим арьс бэлтгэж тушаахаас гадна 100-200 толгой үржлийн сайжруулагч хуц бэлтгэж байсан байна. 1990 онд 58.5 мянган толгой хоньтой байхдаа каракулийн "Сүмбэр" үүлдэр болж батлагджээ,

## 1. Хүн амын тоо, байршил

Хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн цахим санд Говьсүмбэр аймгийн харьят 17.5 мянган хүн бүртгэлтэй байгаагаас 1.7 хувь нь гадаадад оршин сууж байна. Нийт хүн амын 98.3 хувь нь суурин хүн ам байна. Суурин хүн амын тоо өмнөх сноос 3.2 хувиар нэмэгджээ.

Суурин хүн амын 73 хувь буюу 17.2 мянга нь аймгийн төвийн сум буюу Сүмбэр суманд, 5.3 хувь буюу 1.2 мянга нь хөдөөгийн сум болох Баянтал, Шивээговь сумдад 20.1 хувь нь амьдарч байна.

### Хүснэгт 1. Хүн амын тоо, байршилаар

	2017	2018
Нийт хүн ам	17387	17489
Аймгийн төв	10439	10447
Сумын төв	3077	3121
<u>Хөдөө</u>	3871	3921

Суурин хүн амын 60.2 хувь нь аймгийн төвд, 17.8 хувь нь сумын төвд, үлдсэн 22.4 хувь нь хөдөөд амьдарч байна.

## 1.4. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ, ЦАГ УУРЫН ОНЦЛОГ

Нутгийн хамгийн өндөр цэг нь далайн төвшнөөс дээш 1620 метр. Уур амьсгалын хувьд хуурайдуу сэргүүтэр. Өвлийн улиралд хамгийн хүйтэн нь -33 хэм, зуны улиралд хамгийн халуун нь +32 хэм хүртэл дулаарах хандлага тохиолддог. Жилдээ 200-250 мм хур тунадас унадаг нь Говийн бүсийн дунджаас илүү юм. Тал хээрийн хүрэн, хүрэн цайвар хөрстэй. Хонь, тэмээ, үхэр, ямаа, адууны аж ахуй эрхлэхэд нэн тохиромжтой. Усан хангамжийн хувьд өрөмдмөл, богино яндант, энгийн, бетонон хашлагатай худаг 246 байгаагаас Сүмбэр суманд 197, Баянтал суманд 15, Шивээговь суманд 34 худаг байна. Бэлчээрийн усан хангамжинд зориулагдан Сүмбэр суманд 188, Баянтал суманд 8, Шивээговь суманд 28 бүгд 224 худаг ашиглагдаж байна. Тус аймгийн нутагт байнгын ундрагатай Хулгар, Уулзвар, Цоорхой, Хүхээ, Цагаан Ус, Уст ханан, Шивээ зэрэг 43 ил задгай горхи булаг шанд бий. Нутгийн баруун хойд талаар хялгана, харгана, баруун өмнөд талаар бударгана дэрс, зэрэг голлосон тойрмын ургамал голлох бөгөөд бэлчээрийн өвөл хаврын даац нь дунджаар 08-1,0 центнер га, зун намрын даац нь 2,5-3,0 центнер га-гийн нөөцтэй тул 80,0 мянгаас илуу малыг бэлчээрээр хангах боломжгүй.



Салхины хамгийн их хурд 25 м/секунд. Салхины чиглэлийг авч үзвэл 1-р сарын мэдээгээр хойд, баруун хойд, зуун зүгийн салхи голлодог. Салхигүй тохиолдол 22 хоног. Салхины дундаж хурд нь хойд зүгийн салхи 2-4 м/ сек, баруун хойд зүгийн салхи 4-6 м/ сек, баруун хойд зүгийн салхи 2-4 м/ сек байдаг. 7-р сарын салхины мэдээг авч үзвэл салхигүй хоног 21, хойд зүгийн салхи 18 м/сек, баруун хойд зүгийн салхи 4-6 м/сек, зуун хойд зүгийн салхи 2-4 м/сек, баруун урд зүгийн салхи 2-4 м/сек байдаг. Аймгийн нутагт хүйтэвтэр хоногийг авч үзвэл хамгийн олон нь 122, хамгийн цөөн нь 95, хүйтэрдэггүй хоног 80-100 байдаг.

#### 1.5. ГОВЬСУМБЭР АЙМГИЙН АМЬТНЫ АЙМГИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ, АМЬТДЫН АМЬДРАХ ОРЧНЫ ОНЦЛОГ

Аймгийн нутаг дэвсгэр нь Монгол орны био-газарзүйн мужлалаар (Цэгмид 1969, Грубов 1982) Төв Халхын хээр, Дорнод Говийн зааг нутагт хамарагдана. Нутгийн дийлэнх хэсгийг хуурай хээр эзлэх тул амьтны аймгийн зүйлийн бүрэлдэхүүнд хээрийн амьтад зонхилдог. Түүнчлэн говь цөлийн амьтад ч цөөнгүй бий.

Тухайлбал цоохор хонин гүрвэл, дэлдэн зараа, говийн ногтруу зэрэг манай орны говь цөлийн бүсэд өргөн тархалттай амьтдын зэрэгцээ монгол болжмор, шоорон эвэрт болжмор, цагаан зээр зэрэг тал хээрийн амьтад Говьсумбэр аймгийн нутаг дэвсгэрт цуг оршин амьдарч байна.

Аймгийн нутгийн дийлэнх хэсгийг эзлэн орших тэгш талархаг хуурай хээрийн дунд дээр бүхий нам хотос газруудад булаг шанд, нуурууд бий. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас горхи, булаг, нууруудын усан сан хатаж багассан хэдий ч Уулзварын гол, Гашууны булаг, Хурын Ногооны тойром, Бөхтийн улаан нуур, Цайдам нуур, Хаялга нуур зэрэг нүүдлийн шувууд зусаж үрждэг, дайрч өнгөрдөг, ан амьтад ундаалдаг чухал газрууд бий.



Зураг 3. Ус намгийн шувууд Хаялга нуур 7-р сар



Зураг 4. Хурын ногооны тойром зэгсэнд зарим нүүдлийн шувууд үрждэг.

Хуурайшилт ихтэй IV, V, VI саруудад аймгийн нутаг дэвсгэрдэх ихэнх шувууд, зэрлэг амьтад уст цэгүүдийг бараадаж байршдаг.

Говьсүмбэр аймгийн байгаль орчин, амьтны аймагт хамгийн чухал нөлөөтэй газар бол Чойрын Богд, Чингэлийн хад, Сансар уулууд юм. Эдгээр уулс нь аймгийн зүүн талд баруун хойноос зүүн урагш 20 гаруй км сунаж тогтсон, боржин цохио хад ихтэй, ууландаа агуй нүх ихтэй, олон зүйлийн ургамалтай, бэлчээр сайтай, хүйтний улиралд цасан бүрхүүл харьцангуй удаан тогтох зэрлэг амьтдын унд болдог тул аргаль зэрэг уулын туруутан, тас, бүргэд, шонхор, сар зэрэг махчин шувууд, олон зүйлийн мэрэгч амьтад, чоно үнэг хярс зэрэг махчин амьтдын үндсэн байршил нутаг болно. Иймд 2011 онд Чойрын Богд уулыг улсын тусгай хамгаалалтад Байгалийн Нөөц Газрын ангилалаар авсан.



Зураг 5. Чойрын Богд уул, 2019 оны 9-р сар

Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрийг бүрэн хамарсан шинжлэх ухааны үндэслэлтэй амьтны судалгаа бага хийгджээ. Ихэвчлэн дэд бүтэц, уул уурхайн төслүүдийн байгаль орчны суурь судалгаа болон зарим нэг амьтдын тооллого, судалгааны хугацаанд хэсэгчилсэн судалгаанууд хийгдсэн байдаг. Аймгийн нутаг дэвсгэрийн хүрээнд тусгайлсан биологийн олон янз байдлын судалгаа бага хийгдсэн нь Говьсүмбэр аймаг засаг захиргааны хувьд бусад аймгуудаас сүүлд байгуулагдсантай холбоотой байж болох юм.

Монгол орны гадаргын усны нөөц багатай цөлөрхөг хээрийн бүсэд хоёр нутагтан амьтдын тархалт хязгаарлагдмал байдаг. Хоёр нутагтан амьтдаас монгол бах *Bufo raddei* нь аймгийн хойд нутаг Хэрлэн голын сав дугуу тохиолдоно. Харин мөлхөгч амьтдаас (Мөнхбаяр нар, 2001) цоохор хонин гүрвэл *Phrynosaurus versicolor*, монгол гүрвэл *Eremias argus*, рашааны могой *Elaphe dione*, бамбай хоншоорт мөгий *Gloydius halys* тархсан байна.

Монгол орны шувуудын олонх нь нүүдлийн шувууд байдаг. Тэр тусмаа цөлөрхөг хээрийн бүсэд тааралдах шувуудын дунд нүүдлийн шувууд гол байр суурийг эзэлнэ. Гэвч тус аймгийн шувууны талаар хэвлэлийн мэдээ хомс, бага судлагдсан байна. Гомбобаатар нарын (2011) “Монгол орны шувууны улаан данс” бүтээлээс шүүж үзэхэд аймгийн нутаг дэвсгэрт Монгол орны суурин шувуудаас шоорон эвэрт болжмор, дэрсний жиргэмэл, монгол болжмор, хээрийн боршувуу, монгол божирог, хадны бор шувуу, хон хэрээ, жунгаа, говийн ногтруу, шилийн сар, тарважи бүргэд, цармын бүргэд, начин шөнхөр, идлэг шөнхөр зэрэг зүйлүүд байдгийг дурьдజээ.

Батсайхан (2010), Цэнджав (2004), Clark (2006) нарын бүтээл болон өөрсдийн өмнөх судалгааны үр дүнгээс шүүж үзэхэд аймгийн нутаг дэвсгэрт жижиг хөхтөнөөс сибирь малтаахай, шивэр алагдаага, дагуур зурам, монгол чичүүл, хэргэлзий оготно, үлийн цагаан оготно, хадны барагчин, хөх шишүүхэй, орог зусаг, гэрийн хулгана, бор туулай, махчидас өмхий хүрэн, мануул, хярс үнэг, шар үнэг, саарал чоно, тал хээрийн туроутнаас цагаан зээр, уулын туроутнаас аргаль зэрэг хөхтений зүйлүүд тархжээ.

## 1.6. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН УРГАМЛЫН АЙМГИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Говьсүмбэр аймгийн ургамлын аймаг, ургамалжлын судалгаа Монгол орны ургамлын аймгийг судлах явцад зохих хэмжээгээр хийгдэж ирсэн байна. БОНХЯ, Говьсүмбэр аймгийн БОАЖГ-ын захиалгаар ШУА-ийн Ботаникийн хүрээлэнгийн Б.Мөнжаргал, Ч.Дугаржав, Н.Нарантуяа, М.Ургамал, Э.Ариунбаяр нар “Говьсүмбэр аймгийн зарим ашигт ургамал” судалгааг 2014 онд Монгол орны ургамал газар зүйн Дундад Халхын хээрийн болон Дорноговийн цөлөрхөг хээрийн тойргуудын хээрийн бүсийн тодорхой газар нутгаар судалгаа явуулж, ургамлын цуглувалга бичиглэл хийснийг боловсруулж 42 овогт хамаарах 116 төрлийн 187 зүйлийн ургамал ургаж байгааг бүртгэнээс ашиглалтанд өртөмтгий 23 овгийн 25 төрлийн 29 зүйл, үүнээс нэн ховор 4 зүйл, ховор 2 зүйл, тархац нөөцөөр харьцангуй арвин 23 зүйл ашигт ургамлын товхимол гаргасан байдаг.

Уг судалгааны үр дүнгээс харахад ургамалжлын хувьд “бүс нутгийг ерөнхийд нь авч үзвэл ургамлын бүрхэвчийн хувьд 40-60% бүрхэцтэй, төв болон өмнөд хэсэгтээ сийрэг, умарт хэсэгтээ харьцангуй нягт арвитай ургамлан нөмрөгтэй, дараах ургамалжлын бүлгэмдэл байна. Үүнд:

- Дундад Халхын хуурай хээрийн бүсийн элсэргэг хүрэн хөрсөнд ургах ботуульжижиг дэгнүүлт үетэн- харганат болон ботууль-хялганат хээр,
- Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогийн тэгш өндөрлөг, бэсрэг уулсын хайргархаг, элсэргэг бор хөрсөнд ургах баглуур- таана- хялганат хээр өмнөт хэсэгтээ зонхилно гэж товч оруулсан байгаа бөгөөд дээрх судлаачдын бүртгэсэн Алтан Бэрмэг (*Limonium aureum* (L.) Hill et Ktze.), Толбот Бэрээмэг (*Ametelia guttata* Bge) гэсэн 2 зүйл ургамлыг бид олоогүй нь говь цөлд ургадаг эдгээр ургамал энд ургах магадлал багатай, нөгөө талаас эдгээр ургамлын солбицлын цэг байхгүй байгаа нь үнэмшилгүй байсан.

Говьсүмбэр аймгийн бэлчээрийн хянан баталгааны зургаас харахад бэлчээрийн төрөл ерөнхийдөө төстэй байгаа боловч бүлгэмдэлийн нэршлийг тодруулах, бэлчээрийн төрлийн хил заагийг шинэчлэн тогтоох шаардлагатай байсан.

Бид 2017 оны Биологийн төрөл, зүйлийн судалгаагаар Говьсүмбэр аймгийн нутагт нийт 43 овог, 136 төрөл, 240 зүйл бүртгэнээс 55 зүйл нэг наст өвслөг ургамал (22.92%), 145 зүйл олон наст өвслөг ургамал (60.42%), 366 зүйл сөөг сөөгөнцөр, заримлаг сөөг ургамал (15.0%), 4 зүйл модлог ургамал (1.67%) байгааг илрүүлсэн бөгөөд түүнээс, 193 зүйл бэлчээрийн (80.4%), төрлийн 73 зүйл эмийн ашигт (30.4%), 57 зүйл хөл газрын ургамал (23.75%) байх ба 198 зүйл нь элбэг, 10 зүйл ховор, 4 зүйл үлдэц, давхардсан тоогоор 10 зүйл Монголын унаган, 21 зүйл Монголд байгаа завсарын унаган ургамал бүртгэгдсэн байгаа нь бүх ургамлын 17.5% нь хамгаалалтанд авах шаардлагатай ургамалд багтаж байгаа дүгнэлт гаргасан.

## 1.7. АРГАЛЬ ХОНИНЫ БИОЛОГИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

### 1. АРГАЛЬ ХОНИНЫ БИОЛОГИЙН ҮНЭЛГЭЭ

#### 1.1. АНГИЛАЛ ЗҮЙ

Хүрээ: Хөвчтөн /Chordata/

Аймаг: Амьтан /Animal/

Анги: Хөхтөн /Mammalia/


Баг: Туруутан /Artiodactyla/

Овог: Тугалмайтан /Bovidae/

Төрөл: Аргаль хонь /Ovis ammon/

Зүйл: Говийн аргаль /O.a.darwini/

Алтайн аргаль /O.a.ammon/



#### 1.2. БИЕИЙН ГАЛБИР, ХЭМЖЭЭ БА ӨНГӨ ЗҮС

Хүнд лагс биетэй, хөл харьцангуй урт. Биеийн урт 140-150 см, сэрвээний өндөр 120-125 см. Угалз 40-200 кг, хомь 27-66 кг. Угалз хомь хоёулаа эвэртэй.

- ✓ Угалзын эвэр мушгиран хэлбэртэй бөгөөд урт, бүдүүн /58-150 см/, хаяа 170 см хүрэх нь бий. Түүний эврийн угийн диаметр 40-44 см.
- ✓ Хомийн эвэр жижиг /25-35 см/, мушгиа багатай

Зуны зүс хүрэвтээр бор, цайвар. Харин өвлийн зүс цайвар. Толгойн ясны суурийн /кондилобазаль/ урт 230-290мм. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 0/1; бага араа 3/3; их араа 3/3 = 32

#### 1.3. АМЬДРАХ ОРЧИН

Өндөр уул - Монгол Алтай, Говь-Алтай тэдгээрийн салбар уулс, зүүн гарын болон алтайн өвөр говийн уулс, Өмнөговь, Дорнговийн бэсрэг уулс, Төв халхын тал хээрийн зарим намхан уулс, Хан хөхийн нуруу, Хангайн хөвчийн нуруу, түүний өмнө бэлийн уулсаар хэсэгчилсэн тархацтай. Монголын умар хязгаараас өмнөд хязгаар хүртэл уулын тайга, уулын ойт хээр, хээр, цөлийн бүс бүслүүрт тархан амьдарна.

#### 1.4. ИДЭШ ТЭЖЭЭЛ

Сүрэглэн амьдрах ба намар, өвөл олноороо сүрэглэнэ. Зуны улиралд өглөө ба оройд идээшилдэг бол өвлийн улиралд өдрийн турш идээшилдэг. Элдэв зүйлийн өвслөг ургамлууд, үет ургамлууд голдуу идэх бөгөөд өвлийн улиралд сөөглөг ургамлын мөчир иднэ. Үүнд таана, баглуур, хялгана зэрэг орно. Ус болон бэлчээрийн нөөцөөс хамааран улирлаар бэлчээрээ сэлгэж байрлана.

#### 1.5. ҮРЖИЛ

Ороо хөөцөөнд Х сард орж, нэг угалз 20 хүртэлх хомь хураана. Орооны бус үед угалз, хомь тусдаа сүрэглэнэ. Хээл тээх хугацаа 150 орчим хоног. Жилд нэг удаа буюу III- IV сард төллөх ба ихэвчлэн 1, хаяа ихэрлэнэ. Үржилд 2-3 насандаа оролцно. Байгалийн нөхцөлд 10-18 жил амьдрана.

#### 1.6. ЗАН ТӨРХ

Аргаль хонь нь сүргийн маш нарийн зохион байгуулалттай амьтад бөгөөд жилийн ихэнх улиралд нэг хүйсийн олон бодгаль (ихдээ 100 хүртэл тоотой) сүрэглэн амьдардаг. Зуны халуунд жалга, гуу, хадны сүүдэрт хэвтэж, үдэш, өглөөний сэруүнд өндөр уулын зоо нуруугаар салхи сөрөн явж идээшлэнэ.

### 1.7. НҮҮДЭЛ ШИЛЖИЛТ, ӨВӨЛЖИЛТ

Цөл хээрийн бэсрэг уулс, аараг толгодод цас, задгай ус, өвс ногоо дагаж улирлаар хол ойр нүүдэллэж бэлчээрээ сэлгэдэг. Алтайн нуруунд 3500м хүртэл, Өмнөговь, Алтайн өвөр говьд 1100м-ээс дээш, Хөвсгөлд 1250-2500м өндөрт нутаглана. Алтай, Хангайн уулсад зун мөнх цасны зах хүртэл нүүдэллэн тагийн нуга, царам, ар хажуугаар бэлчиж, өвөл уулын дундаас доош, бэл энгэр газар байрлана.

### 1.8. АМЬДРАЛЫН ТҮГЭЭМЭЛ УЛ МӨР

Ус уусан газрын ойролцоо, шавар дээр үлдсэн мөр, үс, хэвтэр, хоргол зэргээр нь таних боломжтой.

## 2. ХАМГААЛЛЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ

### 2.1. МОНГОЛ ОРНЫ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН СТАТУС

*Ovis ammon* Монгол улсын улаан номонд (1997) орсон бөгөөд “Амьтны тухай хууль”-д “ховор” гэсэн ангилалд орсон байдаг. Бүс нутгийн хэмжээнд “УСТАЖ БОЛЗОШГҮЙ”, зэрэглэлээр үнэлэгдсэн. Амьтны тухай хуульд аргаль хонийг зөвхөн тусгай сонирхолын чиглэлээр, БОАЖЯамнаас олгосон тусгай зөвшөөрлийн дагуу агнана гэж заажээ. Алтайн аргаль хонь (*Ovis ammon ammon*) нь биеэр хамгийн том бөгөөд лиценци ба зөвшөөрөлд 240000 ам.доллар шаардагддаг. Говийн аргаль хонь (*O.a.darwini*) нь биеэр багавтар бөгөөд 14000 ам. доллалын үнэтэй байдаг. Амьтны тухай хуульд аргаль хонийг жил бүрийн 07 сарын 01- ээс 10 сарын 01 хүртэл тусгай сонирхолын чиглэлээр агнаж, ашиглахыг зөвшөөрдөг. Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтын агналтыг хоригложээ.

Аргаль хонины тархац нутгийн 14 орчим хувь буюу Монгол Алтай, Хангайн өндөр уул, Говийн-Алтай, зүүн гарын болон Алтайн өвөр говьд аргалийн байршил 6146,4 мянган га талбай бүхий 5 газрыг улсын тусгай хамгаалалтанд авсан.

### 2.2. ОЛОН УЛСЫН СТАТУС

Агнуур зүйч, биологич нар одоогоор *O.ammon* 9 зүйлхэнтэй гэж үздэг бөгөөд эдгээрээс 7 нь CITES-ийн 2-р хавсралтанд, харин *O.a.bodgsonii* ба *O.a.nigrimontana* хоёр хамгийн их аюулд өртсөн учраас 1-р хавсралтанд оруулсан байна. (1-хавсралтанд орсон амьтныг агнаж ашиглахыг олон улсад хориглосон байдал) IUCN-ийн Улаан номонд алтайн аргаль хонийг маш эмзэг, Говийн аргаль хонийг ховордсон, Казахстаны аргаль хонь (*O.a.collium*) эмзэг, Түүдийн аргаль хонийг (*O.a.bodgsonii*) эмзэг, Хойт хятадын аргаль хонийг (*O.a.jubata*) маш ховордсон, Тянь-Шаны аргаль хонийг (*O.a.karelini*) эмзэг, Кара Тау аргаль хонийг (*O.a.nigrimontana*) нэн ховордсон, Марко поло аргаль хонийг (*O.a.polii*) эмзэг ба Кизилькумын аргаль хонийг (*O.a.severtzovi*) ховордсон гэж тус тус ангилсан байдаг.

## 3. ПОПУЛЯЦИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ / Популяцийн одоогийн төлөөв байдал /

### 3.1. ТАРХАЦ, ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ

ДЭЛХИЙН ТАРХАЦ. ОХУ, Казахстан, Узбекистан, Афганистан, Киргизстан, Пакистан, Тажикстан, Хятад, Энэтхэг, Балба, Монгол, Бутан. Алтайн аргаль хонь Хятад, Монгол, ОХУ, говийн аргаль хонь Хятад, Монголд тэмдэглэгдсэн.

БҮС НУТГИЙН ТАРХАЦ. Монгол орны 15 аймгийн 110 сумын нутгагт амьдардаг. Аргаль хонины тархац болон сүргийн хуваагдал нь хүний буруутай үйл ажиллагаа ( зам тээвэр, уул уурхай, хот суурин, бэлчээрийн мал аж ахуйн тоо толгойн хэт өсөлт гм ) болон байгалийн хүчин зүйлээс ( ган, зуд ) хамаарч өөрчлөгддөг.

### 3.2. ТОО, ТОЛГОЙ ТҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТ

Тоо толгойн хувьд 1975 онд 50,000 бодгаль, 1985 онд өсөж 60000 бодгаль болсон бөгөөд харин 1994 онд популяцийн хэмжээ отцом буурч 20000 бодгаль болсон. (*Reading наар 1997*) 2001 онд 13,000-15,000 болж үргэлжлэн буурсан байдаг. (*С.Амгаланбаатар наар 2002*), Харин 2009 онд хийсэн уулын тuruутны нөөцийн үнэлгээгээр 18,400 гэж үнэлсэн байна. 2009 оноос хойш аргаль хонины нөөцийг одоог болтол нэгдсэн байдлаар тогтоогоогүй байна. Байгаль цаг уур болон хүний буруутай үйл ажиллагаанаас хамаарч тоо толгой нь ихээхэн хэлбэлздэг. Цөл хээрт задгай ус, бэлчээр бүхий байршил нутагт мал бэлчээрлэснээс дайжих, байршил нутаг нь малын бэлчээртэй давхцаж хавчигдан шахагдах, махчин амьтны олз болох, нялх хургыг бүргэд барих, ган зуданд нэрвэгдэх, цөл хээрт цангаж үхэх, уул уурхайн баялагийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрс нэмэгдсэн зэрэг нь аргаль хонины тоо толгой буурахад ихээхэн нөлөөлж байна.

## 4. АСУУДЛЫГ ТОДОРХОЙЛОХ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

### 4.1. АСУУДЛЫГ ТОДОРХОЙЛОХ ЕРӨНХИЙ СУДАЛГАА

Аргалийн тоо толгойг өсгөх, агнуурын нөөц бүрдүүлэхийн тулд зэрлэнг ан амьтад байршидаг нутгийг бэлчээрийг мал сүргээс чөлөөлөх, байгалийн уст цэгийг хамгаалах нь чухал болно. Тухайлбал

- ✓ Бэлчээрийн даац хэтрэн, зэрлэг ан амьтны идээшил нутагруу түрэн орох
- ✓ Идээшил нутагт нь хүн, малын хөдөлгөөн их
- ✓ Ус, булаг шанданд малчид хэтэрхий ойр буун, малаа олноор оруулж байгаагаас шалтгаалан булаг шанд ширгэх зэрэг шалтгааны улмаас янгир ямаа, аргаль хонины тархац нутаг хумигдан, талхлагдаж байгаа учир тоо толгойд нь ихээхэн өөрчлөлт орж болзошгүй.

### 4.2. НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ҮЙЛЧЛЭЛИЙГ СУДЛАХ

Баянхонгор аймгийн хэмжээнд аргаль хонинд учирч буй аюул дарамтын үнэлгээ. Хүчин зүйлсийн үйлчлэлийг харгалзан биологийн ба хүний гэх 2 бүлэгт хувааж “Их”, “Дунд”, “Бага” гэж ялгав.

#### 4.2.1. Биологийн бус хүчин зүйл

**Хүснэгт 1. Аргаль хонинд учирч буй аюул, дарамт**

Аюул дарамтыг үүсгэж буй хүчин зүйл		Аргаль хонь
1	Мал аж ахуйн дарамт	Их
2	Амьдрах орчин доройтох	Их
3	Уст цэгийн хангамж	Дунд
Аюулын нийлбэр дүн		Их

Аргаль хонины популяцид нөлөөлж буй дээрх 3 төрлийн маш хүчтэй илэрч буй аюул, дарамтыг хүний зүгээс бий болгож буй эх үүсвэрийг тодорхойлон нөлөөллийн зэргийг эрэмбэлж үзвэл.

1. Ус, бэлчээрийн ашиглалт их хэмжээгээр
2. Мэдээлэл дутмаг байдал их хэмжээгээр
3. Хуулийн хэрэгжилт сул байгаа нь их хэмжээгээр
4. Агнуурын амьтдын ашиглалт, хамгаалалтад иргэдийн оролцоо сул байгаа нь их хэмжээгээр
5. Суурь судалгаа хангалтгүй хийгдэж байгаа нь их хэмжээгээр
6. Амьдрах орчны доройтол их хэмжээгээр

**Хүснэгт 2. Аргаль хонинд учирч буй аюул, дарамтыг бий болгож байгаа шалтгаан эх үүсвэрийн үнэлгээ**

Аргаль хонинд учирч буй аюул дарамтыг бий болгож буй эх үүсвэр		Аргаль хонь	Үнэлгээний дүн
1	Малын тоо толгой нэмэгдэж бэлчээрийн талхагдал үүссэн	Их	Их
2	Ус, бэлчээрийн зохисгүй ашиглалт, бэлчээрийн ургамлын хэт их ашиглалт (нүүдлийн хуваарийг мөрддөггүй )	Дунд	Дунд
3	Аргаль хонини амьдрах орчин хомостох байдал	Дунд	Дунд
4	Зэрлэг амьтны үнэ цэн, байгаль орчны мэдээлэл дутмаг	Дунд	Дунд
5	Байгаль орчны хуулийн хэрэгжилт сул	Их	Их
6	Агнуурын амьтдын ашиглалт, хамгаалалтад иргэдийн оролцоо, хамтын ажиллагаа сул	Их	Их

#### **Нөхцөл байдлын дүн шинжилгээ**

Шалтгаан үр дагаврын шинжилгээ

**Хүснэгт 3. Шалтгаан үр дагаврын шинжилгээ**

№	Хамгаалахаар Аюул занал сонгосон амьтан, амьдрах орчин	Шалтгаан	Шалтгаан	Шалтгаан
1	Бэлчээр	зохицуулалтгүй Даац бэлчээр ашиглалт	НЬАБН-ийг тодорхойгүй, Бэлчээрийн менежмент байхгүй	- Мэдлэг мую, -эрх зүйн орчин хангалтгүй
2	Аргаль хонь	Хүний шууд Хяналтын болон дам нэлөө тогтолцоо сул, чадавхижагүй сул	Нутгийн иргэдийн оролцоо, идэвх	Хамгаалалтын санаачлагад дэмжлэг бага

Эндээс харахад хэдийгээр биологийн төрөл зүйл, түүний амьдрах орчинд аюул занал байгаа боловч голлох шалтгаан нь хүний үйл ажиллагаатай холбоотой байна. Хүний сөрөг үйл ажиллагааг хүн л зогсоноо. Энд “зогсоох” хүч нь төрийн байгууллагын зөв хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр байна.

№	Хамгаалах-аар	Аюул занал буурсан	Үр дүн	Үр дүн	Үр дүн
1	Бэлчээр	-бэлчээр ашиглалт менежментийн төлөвлөгөөтэй хэрэгждэг болсон байх	Бэлчээрийн АБН-ийн менежментийн төлөвлөгөөн эрх боловсрогдсонхариуцагч байх	АБН-ийн менежментийн удирдлагын эрх нөхөрлөлд очсон байх	-Амьдрах орчныг нь сайжруулахтай холбоотой сургалтуудад хамрагдан чадавхижих - эрх зүйн орчин сайжрах
2	Аргаль хонь	Хүний шууд ба дам нөлөөхяналтын буурах	Хариуцагчдын тогтолцоо сайжирсан байх	АБН-ийг хариуцагч хуулийн этгээд тогтвортой ажиллах боломжтой болсон байх	-АБН-ийг хариуцах, хамгаалах, ашиглах, борлуулах, бусад сургалтуудад хамрагдан мэдлэг чадвар эзэмших, материаллаг баазаар хангагдах зэргээр чадавхижих

## 5. ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

### 5.1. БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

- ✓ Аргалийн ундаалах задгай ус, булаг шандыг сэргээх,
- ✓ Үндсэн байршил нутгийг малын бэлчээрээс чөлөөлөх,
- ✓ Тусгай зориулалт болон хууль бус агууларт тавих хяналтыг сайжруулах,
- ✓ Тархац нутгийг байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл болон нутгийн иргэдэд хариуцуулан хамгаалуулах,
- ✓ Зудын гамшиг тохиолдсон үед биотехникийн арга хэмжээ авах,
- ✓ Уул уурхай ашиглалтын дэд бүтцийн сөрөг нөлөөллөөс хамгаалах зэрэг болно.

### 5.2. ОЛОН УЛСЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ

Биологийн төрөл, зүйл түүний амьдрах орчны хамгаалал, тусгай зөвшөөрлөөр хяналттай ашиглах талаар конвенцийн гишүүн орнуудын эрх, үүргийг дараах байдлаар заасан байдаг.

- ✓ Дэлхийн биологийн төрөл зүйлийн конвенци  
Энэ конвенцид элсэн орсон талууд хамгаалалттай газар нутгийн системийг байгуулах, экосистем, байгалийн бусад амьдрах орчин, популяцийг нөхөн

сэргээхтэй холбогдсон хамгааллын үйл ажиллагааг сурталчлах, сүйдсэн экосистемийг сэргээх, бүрэн бүтэн байдлыг хадгалах, устах аюулд өртөж буй зүйлийг хамгаалах, энэ үйл ажиллагааны төлөвлөгөө, менежментийн бусад арга замыг зохион байгуулах үүрэгтэй.

- ✓ Зэрлэг амьтны зүйлийг хамгаалах конвенци
- ✓ Ховордсон амьтан, ургамлын зүйлийг хамгаалах конвенци  
Конвенцийн 2-р хавсралтанд бүртгэгдсэн ба экспортын зөвшөөрөл, эрхийн бичгийг шаардах замаар энэ зүйл аргаль хонини агнах, худалдах харилцааг зохицуулна. Экспортын зөвшөөрөл нь дараах нөхцөлтэй.
  1. Экспорт нь тухайн зүйлийн амьдран үлдэхэд нөлөөлөхгүй болохыг шинжлэх ухааны зөвлөл баталсан
  2. Тухайн улсын ургамал, амьтныг хамгаалах тухай хууль, тогтоомжийг зөрчөөгүй байх зэрэг болно.

### 6. ЗҮЙЛИЙН ХАМГААЛАЛ

- ✓ Бэлчээр, усаар шаахгүй байх
- ✓ Биотехникийн арга хэмжээг цаг хүндэрсэн үед авах
- ✓ Амьдрах орчныг хамгаалах
- ✓ Бэлчээрийн нөөцийг тогтоох
- ✓ Аргаль хонини ашиглалтаас олсон орлогыг Байгалийн нөөцийн тухай хуулийн 18.1 дахь заалтын дагуу 50%-ийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, аргаль хонини хамгаалал, судалгаа, сурталчилгааны ажилд зарцуулж хэвших

### 7. СУДАЛГАА БА МОНИТОРИНГ

- ✓ Агнуурын бүс нутгуудад байгаль хамгаалагч, нөхөрлөлийн оролцоотой аргаль хонини дөрвөн улирлын судалгааг хийж популяцийг үнэлэх
- ✓ Бэлчээр, идэш тэжээлийн судалгааг хийх
- ✓ Шилжилт хөдөлгөөний судалгааг хийх

### 8. ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСЛЭЛТЭЙ АШИГЛАЛТ

- ✓ Популяцид хал багатай, тогтвортой удаан хугацаанд ашиглах
- ✓ Ашиг нь орон нутгийнхны амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдэх
- ✓ Орлогын тодорхой хувийг хамгааллын менежментэд зарцуулж байх
- ✓ Хамгааллын менежментийн төлөвлөгөөтэй байх
- ✓ Нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежмент хэрэгжүүлэгчид нь тодорхой сургалтанд хамрагдан мэргэшсэн байх
- ✓ Мэдээллээ нээлттэй ил тод байлгах
- ✓ Аливаа асуудлыг дотооддоо ардчилсан зарчмаар шийддэг байх
- ✓ Мэргэжлийн байгууллагын дүгнэлт, саналыг хугацаанд нь заавал хэрэгжүүлдэг байх зэрэг зарчмуудыг баримтлах шаардлагатай.

9. ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН

Агуулга	Тайлбар	Заалт	Эрх зүйн баримт бичиг	
Эко-э.з. үнэлгээ	эр	11 сая төг.	ЗГ-ЫН 23-р тогтоол	
	эм	13 сая төг.		
	Соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар	Эр - 2.2 сая төг. Эм – 2,6 сая төг.	ЗГ-ЫН 23-р тогтоол, 2011	
Байгалийн нөөц ашигласны төлбөр	Алтайд Тусгай Төлбөртэй Говьд	Олзворын жишиг үнэ Төлбөр Хураамж Олзворын жишиг үнэ Төлбөр Хураамж	24 000,0 т.н 17 00,0 т.н 4 000,0 т.н 14 000,0 т.н 10 000,0 т.н 2 000,0 т.н	ЗГ-ЫН 2001 оны 264-р тогтоол
Агаах, барих зөвшөөрөл	Тусгай зориулалтаар	Тусгай зөвшөөрөл	АТХ-ийн 7.5.	
Агаах, барихыг хориглох хугацаа	Жил бүрийн	Агаахыг 10.01-06.30 Амьдаар барихыг 10.20-08.20	АТХ-ийн 9.7.2., 9.8.1.	
Хуулийн хариуцлага	Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр Торгууль Эрүүгийн хариуцлага	Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх	АТХ-ийн 37-р зүйл 3ТХ-н 7.6.1-7.6.5, 11.22.3, 11.22.4 ЭХ-ийн 24.5.1.	

## 1.8. СААРАЛ ЧОНЫН БИОЛОГИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

### 1. СААРАЛ ЧОНЫН БИОЛОГИЙН ҮНЭЛГЭЭ

#### 1.1. АНГИЛАЛ ЗҮЙ

Хүрээ: Хөвчтөн /Chordata/

Аймаг: Амьтан /Animal/

Анги: Хөхтөн / Mammalia/

Баг: Махчид /Carnivora/

Овог: Саарал чоно /Canis lupus/

Англи нэр: Grey wolf



#### 1.2. ТАНИХ ШИНЖ

Дэд зүйлийг ангилахдаа ихэнхдээ түүний зүсийн ялгааг баримталсан байна. Жишээ нь: Тундрын чоно цайвар саарал, ойн чоно шаргал саарал, хээр ба цөлийн чоно зэвхий саарал /ноолуур хөхөвтөр саарал сор нь хар/ зүстэй байна.

Толгой зангар, чих соотон, үзүүр нь шовх. Отгөн нягт үстэй, зоо хэсгээрээ бараан урт сортой. Сүүл сагсгардуу богино. Хумс бараан хүрэн өнгөтэй. Хөлний уланд 5 саарин товхтой. Урд хөлний дунд 2 хурууны саарин товх нийлээгүй байна. Бадриун зэгзгэр мөчтэй. Ер нь нохойтой төстэй. Ялгаатай тал нь толгой том, сүүлээ сөхдөггүй. Харин галзуу чоно л сүүлээ сөхнө. Гэтэл галзуу нохой сүүлээ хавчдаг.

#### 1.3. БИЕИЙН ХЭМЖЭЭ

Бие гүйцсэн чонын биеийн урт 105-160 см, сүүлний урт 35-50 см, жин нь 18-80 кг, толгойн ясны ерөнхий урт 20-22 см, чихний урт 9-12 см, хойд тавхайн урт 20-25 см, шүд нь нэлээд том хүчирхэг, ялангуяа соёо сайн хөгжсөн. Шүдний томъёо: үүдэн шүд 3/3; соёо 1/1; бага араа 2/3; их араа 2/3 = 42

#### 1.4. АМЬДРАХ ОРЧИН

Монгол орны бүх бүс нутагт тохиолдоно. Ихэвчлэн хүний нөлөөнөөс зайдуу бартаа хоргодоц сайтай хад асга бүхий өндөр уул, тайгад түгээмэл амьдрана. Ихэвчлэн тэнэмэл байдлаар амьдарна. Хоногт дунджаар 25-75 км явна. Ихэвчлэн 2-12 толгойгоор сүрэглэнэ. Нэг сүрэгт байх толгойн тоо орооны үед олширно. Гөлөглөх үедээ тодорхой газар орогоно. Уулын чоно асга хадны хонгилд, ойнх унасан модны үндэс доор, торлогийн буц ба хулс зэгстэй газар, хуурай цөл дээр, тал хээрийнх амьтны хуучин нүхэн дотор тус тус гөлөглөж, тэндээ үр төлөө бойжуулна. Тал хээрт чонын нүх гэж байх боловч чоно шинээр нүх ухах нь ховор. Ихэвчлэн порго мэт амьтны хуучин нүхийг томсгож орогнодог. Нүхний хэмжээ янз бүр. Хонгил нь 1-3 м, заримдаа 10 м хүртэл тохиолддог.

#### 1.5. ИДЭШ ТЭЖЭЭЛ

Үндсэн тэжээл нь мах. Жижиг мэрэгчдээс эхлэн том туурайтан хүртэлх амьтдыг барьж иднэ. Мал аж ахуйд асар их хохирол учруулна. Зарим судлаачдын үзсэнээр өдөрт дунджаар 3-5 кг мах иднэ. Өлөн үедээ 10 гаруй килограммыг ч иднэ.

#### 1.6. ҮРЖИЛ

Чоно нэлээд түргэн үржилтэй амьтдын нэг. Анчдын ба чоно судлаачдын тэмдэглэлээс үзэхэд Монголд жилийн 2-р сарын үед хүргэлэлтийн үе болж 62-63 хоног хээлтэй явж 4-р сарын 2-р хагасаас 5-р сарын эхний хагаст 3-12 бэлтрэг төрүүлнэ. Төрсөн бэлтрэгийн дийлэнх нь эм хүйс байна. Бэлтрэг нь 10-11 хоног дээрээ нүдээ нээнэ. 35-40 хоног эхийн

сүү хөхөж, 40-45 хоногтойгоос махан хоолонд орно. Намар эхийгээ дагаж гөрөөнд гарна. З сартай 7-8 бэлтрэг бүхэл бүтэн адууны махыг идсэн тухай тэмдэглэсэн байдаг. Бэлтрэгийг багаас нь ан ав хийхэд эцэг эх чоно нь сургадаг.

#### 1.7. ЗАН ТӨРХ

Ажиглалтаас үзэхэд амьтдыг барихдаа ихэвчлэн бүрхэг, цас, бороо, шуургатай үед буюу үдэш орой шөнийн цагаар барих нь цэлмэг өдрийнхөөс их байна. Өвлийн үед жижиг мэрэгчид зарим амьтад ичээндээ орсон учир мал аж ахуйд үзүүлэх хохирол нь илүү байдаг. Амьтдыг барихдаа отох, өрөөлж хөөх, олуулаа нийлж тал бүрээс нь дайрах, мөсөнд халтиргах, асга хадруу унагах зэрэг олон янзын арга хэрэглэнэ. Шүдний байгуулалт онцлог учир хазсан хэсгээ өм татахаас нааш тавьдаггүй.

#### 1.8. ЭД ЭРХТЭН, БҮТЭЭГДЭХҮҮН, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЛЭЭ

Арьс эд эрхтэнг худалдах болон спорт агнуур, мөн малын дайсан гэж үзэн ихээр агнаж байна. Чонын арьсаар дээл, малгай, хөнжил, дах зэргийг хийж гадаад худалдаанд гаргана. Мөн хөлдөөсөн чоныг бүхлээр нь болон эд эрхтэнг тусгайлан салгаж нойтноор юмуу хатааж худалдаална. Шагай болон соёог гоёл чимэглэлийн зориулалтаар хэрэглэдэг. Нохойтой төстэй учир эд эрхтэнг мэргэжлийн шинжээчдээр тодорхойлуулах шаардлагатай.

#### 1.9. ХОВОРДЛЫН ШАЛТГААН

Уламжлалт анагаах ухаан, дотоод ба гадаадын зах зээлд эрхтэн, арьс, мах, шагай, тархийг ашиглах ба худалдаалахаам болж хараа хяналтгүй, хууль бусаар агнадаг.

### 2. ХАМГААЛЛЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ

#### 2.1. МОНГОЛ ОРНЫ СТАТУС

ОУБХХ-ны улаан дансны шалгуураар манай орны хувьд “Ховордож болзошгүй” /Улаан данс 2006/ зэрэглэлд багтсан.

#### 2.2. ОЛОН УЛСЫН СТАТУС

ОУБХХ-ны улаан дансны шалгуураар олон улсын хувьд “Анхааралд өртөхөөргүй” зэрэглэлд багтана.

#### 2.3. ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ

CITES-ийн II хавсралтанд бүртгэлтэй. Манай оронд түгээмэл тархсан зүйл. 2007-2009 онд тал хээрийн бүс буюу зүүн бүсийн аймаг, сумын зарим нутагт агнахыг хориглож байсан. Саарал чонын тархац нутгийн 13% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

2.4. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Агуулга	Тайлбар	Заалт	Эрх зүйн баримт бичиг
Эко-э.з. үнэлгээ	эр	510.000 төг	ЗГ-ын 23-р тогтоол
	эм	600.000 төг	
Байгалийн нөөц ашигласны төлбөр	Соёл, шинжлэх ухаан, эмчилгээний зориулалтаар	Нэг толгойд 120.000 төг	ЗГ-ын 23-р тогтоол, 2011
	Тусгай Төлбөртэй	Олзворын жишиг үнэ	250,0 т.н
		Төлбөр	160,0 т.н
		Хураамж	65,0 т.н
Агнахыг хориглох хугацаа	Жил бүрийн	11.15-01.31	АТХ-ийн 9.1.5.
Хуулийн хариуцлага	Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр	Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлөх	АТХ-ийн 37-р зүйл
	Торгууль		ЗТХ-н 7.6.1- 7.6.5, 11.22.3, 11.22.4
	Эрүүгийн хариуцлага	Тусгай хамгаалалттай газар нутагт агнах, барих, ашиглах	ЭХ-ийн 24.5.1.

## 1.9. ЦАГААН ЗЭЭРИЙН БИОЛОГИЙН ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

### 1. ЦАГААН ЗЭЭРИЙН БИОЛОГИЙН ҮНЭЛГЭЭ

#### 1.1. АНГИЛАЛ ЗҮЙ

Хүрээ: Хөвчтөн /Chordata/

Аймаг: Амьтан /Animal/


Анги: Хөхтөн /Mammalia/

Баг: Туруутан /Artiodactyla/

Овог: Тугалмайтан /Bovidae/

Төрөл: /Procapra/

Зүйл: Цагаан зээр /Procapra gutturosa/



#### 1.2. БИЕИЙН ГАЛБИР, ХЭМЖЭЭ БА ӨНГӨ ЗҮС

Цагаан зээр нь гадаад байдлаараа хар сүүлт зээртэй нилээн төсөөтэй. Цайвар ухаа, улаан загал зүстэй, хэвлүй цагаан. Өгзөгний цагаан тангийн дээд зах сүүлний угаас дээгүүр байна. Сүүл богино, үзүүрийн бараавтар хэсгээс бусад нь цагаан. Өвдөг, шилбэ бараавтар. Эм нь эвэртэй бөгөөд 180-200мм урт хар бор өнгөтэй.

Зуны зүс нуруу болон хажуу тал шаргалдуу, хэвлүй цагаан. Харин өвлийн зүс 3-5 см урт, өтгөн, цайвар. Биеийн урт 105-148 см, сэrvээний өндөр 62-84 см биеийн жин эрийнх нь 40-45 кг, эмийнх нь жин 30-32 кг хүрдэг. Толгойн ясны суурийн /кондилобазаль/ урт оонын хувьд 23-26 см, шаргачинд 22-25 см. Шүдний томъёо: үүдэн шүд 0/3; соёо 0/1; бага араа 3/3; их араа 3/3 = 32

#### 1.3. АМЬДРАХ ОРЧИН

Дорнод аймгийн Матад, Мэнэнгийн тал, Сүхбаатар аймгийн Уушгийн тал зэрэг дорнод хилийн дагуу намхан аараг толгод, гувээ бүхий хялганатай хээрт байршин амьдрана. Монгол орны Дорнод Монгол, Төв Халх, Умард Говь, Дорнод Говь, Нууруудын хөндийн зүүн хэсэг, Их нууруудын хотгорын хомын талд (нутагшуулсан) тархсан.

#### 1.4. ИДЭШ ТЭЖЭЭЛ

Хялгана бүхий хээрийн дов толгод, ам хөндий, тал хээрт байрлаж өглөө үдшийн сэргүүнд идээшилнэ. Тал хээрийн бүсэд ургадаг бараг бүх төрлийн ургамлыг иддэгээс хялгана, хазаар өвс, ерхөг, ботууль, хиаг, өлөн, дааган сүүл, гичгэнэ, таана, мангир, баглуур, бударгана зэрэг ургамлуудыг голлон иддэг. Ургамлын аль шимтэй хэсэг навч, нахиа, сахал, үр, толгойг цөмж иднэ.

#### 1.5. ҮРЖИЛ

Цагаан зээрийн ороо хөөцөөний үе 12-р сараас эхэлж, 1-р сар хүртэл үргэлжилнэ. Шаргачин хээлээ 5-6 сар тээж 6-р сарын сүүлч, 7-р сарын эхээр голдуу сөнгө янзага гаргана.

#### 1.6. ЗАН ТӨРХ

Цагаан зээр хүйтэнд тэсвэртэй өлчир амьтан тул барагтай цасан шуурга, саохинд уруудахгүй сөрж явдаг онцлогтой. Цагаан зээр ихэвчлэн олон толгойгоор сүрэглэн амьдардаг бөгөөд намар 100-аас дээш заримдаа хэдэн зуугаар ч сүрэглэдэг.

#### 1.7. НҮҮДЭЛ ШИЛЖИЛТ, ӨВӨЛЖИЛТ

Ус, ундаа бэлчээрийн соргогыг дагаж улирлаар олон зуун км хол нүүдэллэнэ.

#### 1.8. ХОВОРДСОН ҮНДЭСЛЭЛ

Албан ёсны агнуурын тооноос хууль бус агнуурын хэмжээ хэд дахин давж, өргөн хүрээгээр агнадаг нь ховордлын шалтгаан болдог. Бэлчээрлэх нутаг хавчигдаж, халдварт өвчнөөр өвчлөх, зудтай өвөл энэ зүйл цагаан зээр ихээхэн хорогдог.

## **2. ХАМГААЛЛЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ**

### **2.1. МОНГОЛ ОРНЫ СТАТУС**

ОУБХХ-ны улаан дансны шалгуураар манай орны хувьд “Устаж болзошгүй” /Улаан данс 2006/ зэрэглэлд багтсан.

### **2.2. ОЛООН УЛСЫН СТАТУС**

ОУБХХ-ны улаан дансны шалгуураар олон улсын хувьд “Анхааралд өртөхөөргүй” зэрэглэлд багтана.

### **2.3. ХАМГААЛАГДСАН БАЙДАЛ**

Бонны конвенц (CMS)-ийн II хавсралтад бүртгэлтэй. Амьтны тухай хууль (2012)-ийн 9.1.1 дэх заалтаар цагаан зээрийг жил бүрийн 12-р сарын 01-ний өдрөөс дараа оны 8-р сараас сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд ахуйн болон тусгай зориулалтаар агнахыг хориглосон. Сүүлийн 6 жил үйлдвэрлэлийн зориулалтаар агнахыг хориглосон. Төрийн захиргааны төв байгууллагаас олгосон тоо, хязгаарын дотор ахуйн зориулалтаар орон нутагт зөвшөөрөл олгодог. Цагаан зээрийн тархац нутгийн 8% орчим нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаад байна.

## 3. ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН

Агуулга	Тайлбар	Заалт	Эрх зүйн баримт бичиг
Эко-э.з. үнэлгээ	эр эм	500.0 мян төг. 550.0 мян төг.	ЗГ-ын 23-р тогтоол
Байгалийн нөөц ашигласны төлбөр	Үйлдвэрлэл, соёл, шинжлэх ухаан, эмчилгээ, ахуйн зориулалтаар	эр – 100.0 мян эм – 110.0 мян	ЗГ-ын 23-р тогтоол, 2011
Tусгай Төлбөртэй	Олзворын жишиг үнэ Төлбөр Хураамж	250,0 т.н 160,0 т.н 60,0 т.н	ЗГ-ын 2001 оны 264-р тогтоол
Агнахыг хориглох хугацаа	Жил бүрийн	12.01-08.31	АТХ-ийн 9.1.1.
Хуулийн хариуцлага	Амьтны аймагт учирсан хохирлын нөхөн төлбөр Торгууль Эрүүгийн хариуцлага	Эко-э.з. үнэлгээг 2 дахин өсгөж төлэх Тусгай хамгаалалттай газар нутагт агнах, барих, ашиглах	АТХ-ийн 37-р зүйл ЗТХ-н 7.6.1- 7.6.5, 11.22.3, 11.22.4 ЭХ-ийн 24.5.1.

**1.10. ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН “СҮМБЭР” СУМЫН АРГАЛЬ ХОНИНЫ БАЙРШИЛ, БИОЛОГИЙН НӨӨЦ, СҮРГИЙН БҮТЭЦ**

Бид 378,2 км<sup>2</sup> дээж талбайд ажиглалт бүртгэл хийсэн ба нийтдээ аргаль хонины 10 сүргийн 106 бодгаль үзэж тэмдэглэн нас, хүйсээр нь тодорхойлсон.

Бидэнд харагдаагүй аргаль хонь байж болно. Тэмдэглэгдсэн аргаль хонины тоонд экстраполяц хийгээгүй, аргаль хонины нөөц нь 09-10-р сарын байдлаар  $151 \pm 8$  орчим байна.

*Хүснэгт 4. Судалгаанд хамрагдсан талбай*

Агнуурын бус нутаг	Сорилын талбай /км <sup>2</sup> /	Дээж талбай /км <sup>2</sup> / = S <sub>d</sub> S <sub>d</sub> =W*L = 331 км <sup>2</sup>			Эзлэх хувь
		Замлалын урт/L/	Замлалын өргөн/W/		
“Сүмбэр”	472.8км <sup>2</sup>	94,6 км	3.5 км		70%

*Хүснэгт 5. “Сүмбэр” Агнуурын бус нутагт хийсэн судалгааны үед тэмдэглэгдсэн аргаль хонины тоо толгой*

№	IY анги	III анги	II анги	I анги	Угалз	Хомь	Төлөг	Хурга	Танихгүй	Нийт
1	-	1	2	1	4	5	2	1	-	12
2	2	1	1	-	4	4	2	-	-	10
3	-	1	-	2	3	4	1	1	1	9
4	1	-	1	1	3	3	1	1	-	8
5	-	1	1	2	4	6	3	3	-	16
6	-	1	-	2	3	4	2	1	-	10
7	1	-	2	1	4	3	1	1	1	9
8	1	2	-	-	3	4	3	1	-	11
9	1	1	-	1	3	4	2	-	-	9
10	-	-	2	1	3	3	2	1	1	9
	6	8	9	11	34	40	19	10	3	106


“Сүмбэр” АБН орчимд 10 сүргийн 106 аргаль хонь тэмдэглэсэн.

Аргаль хонины биологийн нөөц нь:

$$Ns = \frac{Ss * Nd}{Sd} \quad Ns = \frac{472,8 * 106}{331} \sim 151 \pm 8$$

“Сүмбэр” Агнуурын бус нутагт 9-10-р сарын байдлаар аргаль хонины биологийн нөөц нь ойролцоогоор  $151 \pm 8$  гэж үнэлэгдэж байна.

Цаашид сар бүрийн мониторингийн мэдээг ашиглавал илүү бодитой үнэлэгдэнэ



Зураг 6. Говьсумбэр аймаг Сүмбэр сум аргаль хонины сүрэг

Диаграмм 1. Аргаль хонины сүргийн бүтэц




Сүргийн бүтцийн харьцааг үзвэл 34 буюу 32% нь угалз, 40 буюу 38% хомь, 19 буюу 18% нь төлөг, 10 буюу 9% хурга, 3 буюу 3%-ийг нь таниагүй байна.

Диаграмм 2. Угалз, хомийн харьцаа



Угалз, хомийн харьцаа тухайн популяцийн бүтэц хэвийн байгаа эсэхийг тодорхойлоход гол үзүүлэлт болдог. Энд угалз, хомийн харьцааг тоймловол 1:1.1, байгаа нь энэ нутагт хүйсний харьцаа хэвийн байгааг харуулж байна.

Диаграмм 3. Аргаль хонины нөхөн үржлийн чадавхи



Нөхөн үржил: Популяцийн нөхөн үржлийн чадавхийг 100 эхэд ноогдох 1 настай бодгалийн буюу бие даах чадвартай, хамгийн бага насны бодгалийн харьцаагаар

тогоох нь зүйтэй байдаг. “Сүмбэр” АБН орчимд 40 хомь, 19 төлөг тэмдэглэгдсэн. Эндээс харахад аргаль хонины популяцийн нөхөн үржлийн чадавхи **47.5%** байна.

#### 1.11. СҮМБЭР СУМЫН “ХАЛЗАН УХАА” АБН-Н ЦАГААН ЗЭЭРИЙН БАЙРШИЛ, БИОЛОГИЙН БОЛОН АГНУУРЫН НӨӨЦ, СҮРГИЙН БҮТЭЦ

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын “Халзан ухаа” АБН нь 963.5 км<sup>2</sup> талбайтай бөгөөд 520,3 км<sup>2</sup> дээж талбайд ажиглалт бүртгэл хийсэн ба нийтдээ цагаан зээрийн 9 сүргийн 830 гаруй бодгаль үзэж тэмдэглэсэн.

*Хүснэгт 6. Судалгаанд хамрагдсан талбай*

Агнуурын бүс нутаг	Сорилын талбай /км <sup>2</sup> /	Дээж талбай /км <sup>2</sup> /= S <sub>d</sub> S <sub>d</sub> =W*L= 520,3 км <sup>2</sup>			Эзлэх хувь
		Замлалын урт/L/	Замлалын өргөн/W/		
“Халзан ухаа”	963.5км <sup>2</sup>	104 км	5 км		54%

*Хүснэгт 7. “Сүмбэр” Агнуурын бүс нутагт хийсэн судалгааны үед тэмдэглэгдсэн цагаан зээрийн тоо толгой*

Ооно	Шаргачин	Янзага	Таниагүй	Нийт
230	380	160	60	830

“Халзан ухаа” АБН орчимд 9 сүргийн 830 гаруй цагаан зээр тэмдэглэсэн.

Цагаан зээрийн биологийн нөөц нь:

$$Ns = \frac{Ss * Nd}{Sd} \quad Ns = \frac{963,5 * 830}{520,3} \sim 1540 \pm 45$$

“Халзан ухаа” Агнуурын бүс нутагт 9-10-р сарын байдлаар цагаан зээрийн биологийн нөөц нь ойролцоогоор **1540±45** гэж үнэлэгдэж байна.


Цаашид сар бүрийн мониторингийн мэдээг ашиглавал илүү бодитой үнэлэгдэнэ.

Диаграмм 4 "Халзан ухаа" агнуурын бус нутгийн цагаан зээрийн сүргийн бүтэц



Сүргийн бүтцийн харьцааг үзвэл 230 буюу 28% нь ооно, 380 буюу 46% шаргачин, 160 буюу 19% нь янзага, 60 буюу 7%-ийг нь таниагүй байна.

Диаграмм 5. Хүйсийн харьцаа



Ооно, шаргачингийн харьцаа нь тухайн популяцийн бүтэц хэвийн байгаа эсэхийг тодорхойлоход гол үзүүлэлт болдог. Энд ооно, шаргачингийн харьцааг тоймловол 0,6:1 байгаа нь энэ нутагт хүйсний харьцаа хэвийн бус байгааг харуулж байна.

Диаграмм 6. Цагаан зээрийн нөхөн төлжилтийн чадавхи



Нөхөн төлжилт: "Халзан ухаа" АБН орчимд 380 шаргачин, 160 янзага тэмдэглэгдсэн. Үүнээс харахад цагаан зээрийн популяцийн нөхөн төлжилтийн чадавхи 42% байгаа нь өндөр үзүүлэлт юм

**1.12. БАЯНТАЛ СУМЫН “ХАЛЗАН “БАЯН” АБН-Н ЦАГААН ЗЭЭРИЙН БАЙРШИЛ,  
БИОЛОГИЙН БОЛОН АГНУУРЫН НӨӨЦ, СҮРГИЙН БҮТЭЦ**

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын “Баян” АБН нь 333,9 км<sup>2</sup> талбайтай. 520,3 км<sup>2</sup> дээж талбайд ажиглалт бүртгэл хийсэн ба нийтдээ цагаан зээрийн 7 сүргийн 710 гаруй бодгаль үзэж тэмдэглэсэн.

*Хүснэгт 8. Судалгаанд хамрагдсан талбай*

Агнуурын бус нутаг	Сорилын талбай /км <sup>2</sup> /	Дээж талбай /км <sup>2</sup> /= S <sub>d</sub> Sd=W*L= 267 км <sup>2</sup>		
		Замлалын урт/L/	Замлалын өргөн/W/	Эзлэх хувь
“Баян” АБН	333.9 км <sup>2</sup>	89 км	3 км	80%

*Хүснэгт 9. “Баян” Агнуурын бус нутагт хийсэн судалгааны үед тэмдэглэгдсэн  
цагаан зээрийн тоо толгой*

Ооно	Шаргачин	Янзага	Таниагүй	Нийт
180	320	140	70	710

“Баян” АБН орчимд 7 сүргийн 710 гаруй цагаан зээр тэмдэглэсэн.


Цагаан зээрийн биологийн нөөц нь:

$$Ns = \frac{Ss*Nd}{Sd} \quad Ns = \frac{333.9*710}{267} \sim 890 \pm 35$$

“Баян” Агнуурын бус нутагт 9-10-р сарын байдлаар цагаан зээрийн биологийн нөөц нь ойролцоогоор **890±35** гэж үнэлэгдэж байна.


Цаашид сар бүрийн мониторингийн мэдээг ашиглавал илүү бодитой үнэлэгдэнэ.

Диаграмм 7. “Баян” агнуурын бүс нутгийн цагаан зээрийн сургийн бүтэц



Сургийн бүтцийн харьцааг үзвэл 230 буюу 28% нь ооно, 380 буюу 46% шаргачин, 160 буюу 19% нь янзага, 60 буюу 7%-ийг нь таниагүй байна.

Диаграмм 8. Хүйсийн харьцаа




Ооно, шаргачингийн харьцаа нь тухайн популяцийн бүтэц хэвийн байгаа эсэхийг тодорхойлоход гол үзүүлэлт болдог. Энд ооно, шаргачингийн харьцаа тоймповол 0,6:1 байгаа нь энэ нутагт хүйсний харьцаа хэвийн бус байгааг харуулж байна.

Диаграмм 9. Цагаан зээрийн нөхөн төлжилтийн чадавхи



Нөхөн төлжилт: “Баян” АБН орчимд 320 шаргачин, 140 янзага тэмдэглэгдсэн. Үүнээс харахад цагаан зээрийн популяцийн нөхөн төлжилтийн чадавхи 44% байгаа нь өндөр үзүүлэлт юм




Зураг 7. Цагаан зээрийн сүрэг. Говьсүмбэр аймаг Сүмбэр сумын нутаг

### 1.13. Монгол тарвага (*marmota sibirica*)

**Олон улсын статус:** Анхааралд өртөхөөргүй  
**Монгол улсын статус:** Устаж болзошгүй

Монгол тарвага нь манай улс болон олон улсын хэмжээнд “устаж болзошгүй” ангилалд орсон, аж ахуй болон байгаль хамгааллын өндөр ач холбогдолтой амьтан юм. Монгол тарвага (*Marmota sibirica*) нь дэлхийн хэмжээнд зөвхөн Монгол, ОХУ, БНХАУ-ын нутагт тархсан ба ОХУ, БНХАУ-д ховор амьтны тоонд ордог. Дэлхийн цөм популяци нь Монгол улс бөгөөд хэт агналтын улмаас дэлхийн популяцийн хэмжээ өгцөм буурсан тул “устаж болзошгүй” ангилалд оруулаад байна.

Тарвага нүхний амьдралтай амьтан. Нүхэнд орж биеэ хамгаалах, мөн нүхэндээ эвцэлдэж, үр төлөө бойжуулдаг. Тарвага дош нүхээ удаан хугацаанд засаж ашигладаг. Хангай нуруунд нүхний урт хамгийн уртдаа 22.5 м, гүн 2.8 м байв (Адъяа, 2000). Тарваганы мөч хумс, биеийн голбир бол нүх ухахад гайхалтай зохицсон байдаг. Тарваганы ашиглахгүй орхисон дош нүх нь суусар, өмхий хүрэн, мануул, хярс, үнэг зэрэг олон зүйл амьтны үүрлэх, орогнох орчин болдог тул энэ амьтны экосистемийн өгөөж нь асар их юм.



Зураг 8. Монгол тарвага Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум Чойрын богд уул

### **Говьсүмбэр аймгийн тарваганы тархалт, нөөцийн байдал**

Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг Чойрын богд уул орчимд нутагт Байгаль хамгаалагч, нөхөрлөлийн гишүүдийн хамтаар тарвага үлдсэн цөөн газруудад 2016 онд 20 толгой, 2019 онд 50 толгой тарвага сэргээн нутагшуулсан нь амжилттай өсөж байна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд тарвага бүхий 2 үндсэн байршил байна. Эдгээр нь:

- ✓ Чойрын Богд уулын арын хөндий, Уулзварын голын зүүн талын тал. Энэ хэсэгт 11 бүл 60 гаруй тарвагатай. Ихэнх дошнуудын машин зам дагуу байрлалтай учир хулгайн агнуурт өртөх эрсдэлтэй. Энэ талбайд тарваганы хуучин дош нүхнүүд олон байдаг.
- ✓ Чингэлийн хадан уулс: 8 бүлийн нийт 40 орчим тарвагатай. Энэ хэсэгт тарвага нутагшуулах боломжтой дошнууд бий. Хулгайн агнуурын эрсдэл багатай. Тарвага бүхий болон нутагшуулах боломжтой дошнууд бүхэлдээ Говьсүмбэр аймгийн нутгийн гүнд учраас орон нутгийн нөхөрлөлийн гишүүдэд тулгуурлан тарвага хамгаалах боломжтой байна.

Хулгайн агнуур, хуурайшилт, цөлжилтөөс шалтгаалан сүүлийн жилүүдэд Говьсүмбэр аймгийн хэмжээнд тарваганы нөөц, тархалт эрс буурч, устах аюулд ороод байна. Бэлчээрийн гарц муутай газруудад тарвага нүхнээсээ хол идээшилж аюулд өртөх нь ихэсдэг ба мөн тарга тэвээрэг муутай өвөлжсөний улмаас өлдөх, үржил нь саарах байдалд ордог.

Тарваганы тоо толгойг хамгаалах, тархац нутгийн хүрээнд өсгөж үржүүлэх нь байгаль хамгаалал, аж ахуйн өндөр ач холбогдолтой учраас Говьсүмбэр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас тарвага хамгаалах санаачлага гарган ажиллаж байна.


Бидний зүгээс тарвага нутагшуулах ажлыг дэмжихийн зэрэгцээ одоо байгаа бүл тарвагыг хамгаалах, хууль бус агнуурыг таслах зогсоох талаар ажил зохиох шаардлагатай гэж үзэж байна.

#### **1.14. Идлэг шонхор (*falco cherrug*)**

**Олон улсын статус:** Устаж болзошгүй

**Монгол улсын статус:** Эмзэг

Монгол улс дахь тус зүйлийн тоо толгой буурах хандлагатай байгаа ба нийт бодгалийн тоо толгой 10000-аас цөөн гэж тооцож байна. Хууль бус болон албан ёсны шонхорын худалдаа, цахилгаанд цохиулах, хордолт, амьдрах орчны доройтлын улмаас тоо толгой нь буурч байна. CITES-ийн 2-р хавсралтанд бүртгэгдсэн. 2019 оны 9-р сарын ажиглалтаар аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 6 бодгалийг тэмдэглсэн. Идлэг шонхорын байршилт нь үлийн цагаан оготны тархацтай давхцаж байна.



Зураг 9 Идлэг шонхор Говьсүмбэр аймаг Сүмбэр сум

#### **Шонхорын байршилт**

Байрлал, цэг	Тоо толгой	Тайлбар
Хүрэн цохио 46°21'57.6"N/108°50'18.0"E	3	Үүртэй, үлийн цагаан оготны колонтой
Баян тал 46°42'06.6"N/108°03'48.4"E	1	Залуу шувуу, утасны шон дээр суусан, үлийн цагаан оготны колонтой
Сансар уул 46°23'13.5"N/108°38'05.6"E	2	Нисэж байсан

**1.15. Саарал чоно (*Canis lupus*)**

ОЛОН УЛСЫН СТАТУС: “Анхааралд өртөхөөргүй”

МОНГОЛ ОРНЫ СТАТУС: “Ховордож болзошгүй” /Улаан данс 2006/ зэрэглэлд багтсан.

Саарал чоно нь Монгол орны бүх бүс нутагт тохиолдоно. Ихэвчлэн хүний нөлөөнөөс зайдуу бартаа хоргодац сайтай хад асга бүхий өндөр уул, тайгад түгээмэл амьдрана. Ихэвчлэн тэнэмэл байдлаар амьдарна. Хоногт дунджаар 25-75 км явна. Ихэвчлэн 2-12 толгойгоор сүрэглэнэ. Нэг сүрэгт байх толгойн тоо орооны үед олширно. Гөлөглөх үедээ тодорхой газар орогноно. Уулын чоно асга хадны хонгилд, ойных унасан модны үндэс доор, торлогийн бут ба хулс зэгстэй газар, хуурай цөл дээр, тал хээрийнх амьтны хуучин нүхэн дотор тус тус гөлөглэж, тэндээ үр төлөө бойжуулна. Тал хээрт чонын нүх гэж байх боловч чоно шинээр нүх ухах нь ховор. Ихэвчлэн амьтны хуучин нүхийг томсгож орогнодог. Нүхний хэмжээ янз бүр. Хонгил нь 1-3 м, заримдаа 10 м хүртэл тохиолддог.



Зураг 10 Чойрын бодг ууланд бидний судалгаагаар б толгой саарал чоно байгааг тоогоов.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ЗАРЧИМ АЧ ХОЛБОГДОЛ

### 2.1. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХАМГААЛЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ТҮҮНД ТУЛГАРЧ БҮЙ БЭРХШЭЭЛ

#### Агнуурын менежментийн тухай ойлголт.

“Агнуурын менежмент” гэж “хамгаалалтын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох замаар ан амьтны нөөцийг даацаад нь зохицуулан өсгөх арга хэмжээ” юм.

Агнуурын менежментийг хэрэгжүүлэхэд тодорхой нөхцлүүд хангагдсан байх ёстай.  
Үүнд:

1. Нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежмент (НИТАМ) хэрэгжих нөхцлийг хангахад чиглэсэн эрх зүйн орчин
2. Менежментийг хэрэгжүүлэгч нь мэргэжлийн түвшинд ажиллах чадвартай байх
3. Үйл ажиллагааны мониторинг тогтмол хийгддэг байх
4. Мэдээлэл ил тод байх
5. Ан амьтны зохистой ашиглалт хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн байх
6. Агнуурын менежментийг зөвхөн агнуурын бүс нутагт төдийгүй орчмын бүсийг хамарсан байх зэрэг болно.

#### Нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийг хэрэгжүүлэх шаардлага

Агнуурын менежментийг хэрэгжүүлэх үндсэн зарчмыг өөрчлөх шаардлага өнгөрсөн жилүүдийн буруу практикаас үүдэлтэйгээр урган гарч байна. Хэдэн жилийн өмнө “Ашиглагч нь хамгаалагч байна” гэсэн зарчмыг баримталж байсан нь зөвхөн ашиглах сонирхолыг илүү төрүүлж, хамгаалалтын ажил нь хоцрогдох байдал их гарч байсан. Иймд, дээрх зарчмыг “хамгаалагч нь ашиглах давуу эрхтэй байна” гэсэн зарчмаар өөрчлөх шаардлага гарч байна. Өөрөөр хэлбэл, хамгаалах талаар санаачлагатай ажиллаж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллага ашиглах давуу эрх эдлэх ёстай бөгөөд энэ нь агнуурын менежментийг үр бүтээлтэй хэрэгжүүлэх үндэс юм. Орон нутгийн иргэд тухайн газар орон, байгалийн нөхцөл, түүний өөрчлөлтийн талаар хэнээс ч илүү мэдээлэлтэй байдаг, ан амьтныхаа төлөө хэнээс ч илүү сэтгэл гарган ханддаг. Иймд нутгийн иргэдэд түшиглэсэн менежмент нь үндэслэл, хэрэгжих боломжоороо ямагт илүү байна.

#### Нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийн зарчим

- ✓ Популяцид хал багатай, тогтвортой удаан хугацаанд ашиглах
- ✓ Ашиг нь орон нутгийнхны амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдэх
- ✓ Орлогын тодорхой хувийг хамгааллын менежментэд зарцуулж байх
- ✓ Хамгааллын менежментийн төлөвлөгөөтэй байх
- ✓ Нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежмент хэрэгжүүлэгчид нь тодорхой сургалтанд хамрагдан мэргэшсэн байх
- ✓ Мэдээллээ нээлттэй ил тод байлгах

- ✓ Мэргэжлийн байгууллагын дүгнэлт, саналыг хугацаанд нь заавал хэрэгжүүлдэг байх зэрэг зарчмуудыг баримтлах шаардлагатай

### Тусгай зориулалтын ан зохион байгуулах

- Агнуурын менежментийг хэрэгжүүлэгч нь орон нутгийн төр, захиргааны байгууллага иргэдийн нөхөрлөлтэй хамтран агнуурын бүс нутагтаа “Нарийвчилсан агнуур зохион байгуулалт”-ыг захиалан хийлгэж дүгнэлт, зөвлөмжийг нь хэрэгжүүлж байх
- Нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийн гол зорилго нь агнуураас тодорхой орлого олж байх явдал. Үүний тулд агнуурын зүйлүүдийн популяцийг мониторингийн хэлбэрээр байнга хянаж, мэдээ цуглуулж байх шаардлагатай. Энэ нь ашиглалтад өртөж буй зүйлүүдийн популяци өрүүл байгаа эсэхийг үнэлэх боломж олгоно. Мониторинг нь давуу ба сул талуудтай.

Давуу тал нь:

- ✚ Популяц хэвийн эсэхийг үнэлэх боломжтой болно.
- ✚ Мэдээллийн сан шинэ мэдээгээр байнга баяжигдана.

Сул тал нь:

- ✚ Урт удаан хугацаа шаарддаг
- ✚ Зардал өндөр гардаг
- ✚ Хэрэглэж байгаа арга хэрэгслэлээ байнга хэлэлцэж орчин үеийн шаардлага, стандартуудад нийцүүлэн шинэчилж байх хэрэгтэй болдог.

**Нөхөн сэргээх арга хэмжээ.** Ан амьтны амьдрах орчныг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнд ан амьтныг тухайн байршиж буй орчинд нь тогтвортой ёсгөн үржүүлэх, хамгаалах, зохистой ашиглахын тулд амьдрах орчныг нь сайжруулах ажлыг тогтмол хийх шаардлагатай. Үүний тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

- Давс хужир тавих, мараажуулах
- Булаг шанд, худаг тохижуулж усны хангамжийг сайжруулах
- Сүргийн бүтцийг зохицуулах сонгон буюу заазлах агналт хийх
- Ан амьтдыг сэргээн нутагшуулах
- Байгалийн гамшигт нэрвэгдсэн ан амьтдыг аврах
- Зэрлэг ан амьтанд зориулан тодорхой бэлчээрийг чөлөөлөх

### Агнуурын менежментийн өнөөгийн байдал, түүнд тулгарч буй бэрхшээл

**Олзворын ан зохион байгуулахад тулгарч буй бэрхшээл, шалтгаан.** Агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, нутгийн иргэдийн оролцоог хангах хууль эрх зүйн орчин бүрдээгүй байна. Ан амьтны зохистой ашиглалтыг зохион байгуулахад олон бэрхшээлтэй тулгарч болно.

Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар агнуурын менежментийг шийдвэрлэх буюу ядаж ихээхэн хөнгөвчилж болно. Нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийг хэрэгжүүлэх асуудал “Амьтны тухай хууль”, “Нөхөрлөлийн тухай хууль” болон бусад хуулийр зохицуулагдах ёстой. Уг хуулиудад энэ чиглэлийн зохицуулалт бүрэн дүүрэн

байдаггүй тул нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах, хамтран ажиллах дүрэм, журам боловсруулах шаардлага бий.

### Удирдлага зохион байгуулалтад учирч буй бэрхшээл.

- Ан амьтныг хамгаалж өсгөн үргүүлэх, тогтвортой ашиглахад нутгийн иргэдийн оролцоо тодорхойгүй, нөхөрлөл байгуулагдаагүй
- Ан амьтан агнаж ашигласан төлбөрийн орлогоос эргүүлэн зарцуулах тогтолцоо хэрэгжэхгүй байна
- Мэргэжлийн боловсон хүчин дутмаг  
**Агнуурын нөөцийг зохистой ашиглах, хамгаалахад учирч буй бэрхшээл**
- Идэвхтэн байгаль хамгаалагчдад урамшил, хангамж байхгүй
- Агнуурын бүс нутгийн менежментийг хэрэгжүүлэхтэй холбогдсон эрхзүйн зохицуулалт байдаггүй
- Агнуурын бүс нутаг дахь ан амьтны мониторинг судалгааны цэг, аргачлал эзэмшээгүй, ангийн гаралтай бүтээгдэхүүний боловсруулалт хийх чадваргүй
- Уул уурхайн хэт их ашиглалт хийж байна.

### Сургалт сурталчилгааны ажилд учирч буй бэрхшээл

- Сургалт сурталчилгааны үйл ажиллагааг зохион байгуулах байгууллага, хувь хүнтэй гэрээ байгуулаагүй
- Агнуурын бүс нутаг хамтран хамгаалах нөхөрлөлийн гишүүд сургалтанд хамрагдаагүй байна

### Судалгаа мониторингид учирч буй бэрхшээл

- Мониторингийн судалгааны дээж талбай, цэг болон судалгааны аргачлал байхгүй
- Энэ ажлыг гүйцэтгэх сургалт хийгдээгүй, санхүүгийн дэмжлэг хомс  
**Санхүү, материаллаг баазын хангамжинд учирч буй бэрхшээл**
- Агнуурын төлбөрийн орлогоос санхүүжих хуулийн зохицуулалт байгаа боловч хэрэгждэггүй

### Хяналт, мониторингийн тогтолцоонд учирч буй бэрхшээл

- Талуудын оролцоо бүхий хяналт, мониторингийн зохих тогтолцоо бий болоогүй

### Нийгэм, эдийн засгийн бэрхшээл

- Иргэд байгалийн нөөцийн талаар мэдлэг дутмаг, зөв ойлголт хандлагатай болж эхэлж байгаа боловч байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалтын менежмент, үр ашигийн талаарх ойлголт бага
- Орон нутгийн захиргааны байгууллага, нутгийн иргэдийн нөхөрлөл, менежмент хариуцагчийн хамтын ажиллагааны тогтолцоо сайн бүрдээгүй

### Эрх зүйн орчин хангалтгүйгээс учирч буй бэрхшээл

- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч, орон нутгийн иргэдийн нөхөрлөл, сумын засаг захиргааны байгууллагуудын хоорондын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн баримт бичиг батлагдаагүй
- Эрх зүйн орчны зохицуулах чадвар, уялдаа холбоо мую байгаа нь гол бэрхшээлийн нэг болж байна.

### 2.2. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ

Ан агнуурын менежментийн төлөвлөгөөг аймгийн БОАЖгазар, сумын засаг дарга, нар, нутгийн иргэдийн нөхөрлөл, байгаль хамгаалагч настай хамтран хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.

Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч талууд уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцдаа хангалттай чадавхжих боломжтой бөгөөд үйл ажиллагааны гол арга нь зөвхөн оролцоонд тулгуурласан шийдвэр байх юм.

Энэхүү менежментийн төлөвлөгөөний зарим үйл ажиллагаанууд бүс нутгийн хилийн заагаар хязгаарлагдахгүй, өөрөөр хэлбэл хил залгаа нутагт ч хэрэгжих боломжтой. Учир нь агнуурын амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөн нь энэ хил хязгаарт хашигдахгүй тул сумын бэлчээр болон байгалийн бусад баялгийг ашиглах төлөвлөлттэй уялдуулах, зохицуулах шаардлага гарна. Иймд, энэхүү менежментийн төлөвлөгөө нь байнга баяжигдан өөрчлөгдөж байх уян хатан байх ёстой гэсэн зарчим баримталж байна.

Ан амьтны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа дараах шаардлагуудыг мөрдлөг болгов. Үүнд:

- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд орон нутгийн удирдлага, нутгийн иргэд, нөхөрлөлийн оролцоог хангахуйц бүтэц, зохион байгуулалтын механизмыг бүрдүүлэх хэрэгцээ шаардлагыг хангах
- Учирч буй бэрхшээл, түүнийг үүсгэж байгаа шалтгааныг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаануудыг менежментийн төлөвлөгөөнд бүрэн тусган хэрэгжүүлэх
- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа шийдвэр, хэрэгжүүлэх үйл явц, хяналт нь талуудын идэвхтэй оролцоог хангасан байх
- Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг хангах
- Менежментийн төлөвлөгөө нь тасралтгүй явагдах үйл явц тул тухайн үеийн шаардлага, эрэлт хэрэгцээнд нийцүүлэн улам боловсронгуй болгож өөрчлөлт оруулж байх
- Улс төр, эдийн засгийн нөхцөл болон удирдлагын хувийн сонирхлоос үл хамааран хэрэгжиж байх зэрэг болно.

### Менежментийн төлөвлөгөөний үндэслэл шаардлага

Менежментийн төлөвлөгөөг тус бус нутгийн агнуурын санг удаан хугацааны турш тогтвортой зөв ашиглаж хамгаалах, удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө гэж сийлгэнэ.

Аймгийн ан агнуурын менежмент 2014 онд анх хийгдэж байсан. Үүнтэй холбогдуулан агнуурын бус байгуулагдсан бөгөөд нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийг хөгжүүлэх, мөн давхар менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна. Энэ нь нэг талаас хамгаалалтын ажилд санхүүжилтыг босгох, хамгаалах үйл ажиллагаа төлөвлөн явуулах, нөгөө талаас мэргэжлийн удирдлага, зохион байгуултаар хангагдах боломжтой.

Иймд, аймгийн ан амьтан хамгаалах бус нутгийн үндсэн зорилгыг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог бий болгох, нутгийн иргэд, нөхөрлөлийг чадавхижуулах, байгаль орчны мэдлэгийг дээшлүүлэх, хамгаалалтын чадавхийг бэхжүүлэх, агнуурын сангийн хамгаалалт, ашиглалтын зохистой хэлбэрийг тогтоож, нутгийн иргэдийн оролцоо, сонирхлыг нэмэгдүүлэх, цаашдын тогтвортой ажиллагааг хангах шаардлагаар энэхүү менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

### 2.3. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ОНЦЛОГ, АЧ ХОЛБОГДОЛ

#### Менежментийн төлөвлөгөөний ач холбогдол

Энэхүү менежментийн төлөвлөгөө нь аймгийн агнуурын ан амьтныг хамгаалах эрхэм зорилгыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газар, БОАЖЯ-аас агнуурын талаар баримталж буй бодлогыг үндэс болгон агнуурын бус нутгийн хамгаалалтын үйл ажиллагаанд нутгийн иргэдийг тогтмол, идэвхтэй оролцуулах хамтын ажиллагааг бүх шатанд хөгжүүлэх мөрийн хөтөлбөр болж буйгаараа ач холбогдолтой юм. Менежментийн төлөвлөгөөтэй болсноор ан амьтан хамгааллын үйл ажиллагааны бодлого, чиглэл, хүрэх үр дүн тодорхой болсон байна.

Менежментийн төлөвлөгөө хэрэгжсэнээр:

- Зэрлэг ан амьтны хамгаалалтад талуудын оролцоо, дэмжлэг сайжирч, төлөвшиж тогтвортых боломжтой болох
- Хамтран ажиллагч талууд (менежментийг хэрэгжүүлэгч, нутгийн иргэдийн нөхөрлөл болон орон нутгийн удирдлага) идэвхижих, чадавхижих
- Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, явц, үр дүнг ил тод мэдээлэх тогтолцоо бүрдэх
- Агнуурын бус нутгийн үнэ цэнэ нэмэгдэж, тухайн орчинд амьдардаг нутгийн угуул ард иргэдийн амьдралын нөхцөл сайжрах, түвшин дээшлэх
- Агнуурын ач холбогдол бүхий зүйлүүдийн популяц хэвийн амьдрах нөхцөл бүрэлдэж хүний хүчин зүйлийн сөрөг нөлөөлөл буурах
- Агнуурын санг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах үйл ажиллагаа нэг нь нөгөөгөө нөхөж салшгүй уялдаа холбоотой хийгддэг болох зэрэг олон талын ач холбогдолтой болно.


ГУРАВДУГААР БҮЛЭГ. МЕНЕЖМЕНТИЙН БҮТЭЦ, САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР, ЗОРИЛГО, ЗОРИЛТ, СТРАТЕГИ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

### 3.1. АН АМЬТНЫ МЕНЕЖМЕНТИЙН БҮТЭЦ, САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР

Удирдлага зохион байгуулалтын чадавхижсан бүтэцтэй байх нь менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх гол нөхцөл юм. Удирдлагын үндсэн бүтэц нь тухайн аймагт ан агнуурын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж ба агнуурын бус нутгийг хариуцаж буй нөхөрлөл, түүний удирдах зөвлөл, менежментийг хэрэгжүүлэгч байгууллага байхаар төлөвлөв. Аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө нь агнуурын бус нутгийн менежмент төлөвлөгөөтэй уялдаж хэрэгждэг байх ёстой.

Нөхөрлөлийг зөхих хууль, дүрэм журмын дагуу байгуулж, тухайн өршин байгаа газрынх нь бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

Схем 2 “Говьсүмбэр аймгийн ан агнуурын менежментийн бүтэц”



Санал болгож буй энэ бүтцээр ажилласнаар тулгарч буй асуудлаа өөрсдөө тодорхойлох, шийдвэр гаргах боломжтой болох ба аймаг, сумын төр захиргааны байгууллага, ТББ-үүд, бусад нөхөрлөлүүд, гадаад, дотоодын болон олон улсын байгууллага иргэдтэй харилцан гэрээтэй ажиллаж хамтын ажиллагаагаа өргөжүүлэх замаар зах зээлд тогтвортой ажиллах боломж нэмэгдэнэ.

### 3.2. САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР БА ДУНДЫН САН ХУРИМТЛАЛ

Менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагаануудыг цаг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлж, зорилго зорилтоо ханган биелүүлэхийн тулд хэрэгцээт санхүүжилтийг бурдүүлсэн байх шаардлагатай. Үүний тулд аймгийн ан амьтан хамгаалах санг байгуулж олзворын ан болон бусад агнуураас орсон орлогыг байршуулах нь зүйтэй. Дундын сан нь зөвхөн агнуурын үйлчилгээний хэлс төдийгүй хандив тусламж, өөрийн бусад үйл ажиллагаанаас орлого олох боломжтой байдаг. Үндсэн орлого нь агнуураас орох боловч дараах эх үүсвэрүүдээс орлого олж болно. Үүнд :

1. “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай хууль”-д үндэслэсэн орлого
2. Агнуурын санг хамгаалах ажлыг дэмждэг төслийд дэмжлэг
3. Гар урлал, бичил үйлдвэрлэл зэрэг өөрийн үйл ажиллагаанаас
4. Мал аж ахуйн салбараас олох орлогоос
5. Олон улсын болон гадаадын бусад байгууллагын тусламж
6. Бусад хандив, тусламж

### 3.3. АГНУУРЫН БУС НУТГИЙН МЕНЕЖМЕНТЭД ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх талууд

1. Байгаль орчин, Аялал жуулчлалын яам
2. Говьсүмбэр аймгийн байгаль орчин, Аялал жуулчлалын газар
3. Сумдын Засаг дарга нар
4. Байгаль орчны Улсын хяналтын байцаагч нар
5. Байгаль хамгаалагч нар
6. “Ан агнуурын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд”
7. Нөхөрлөлийн гишүүд
8. Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллага

### 3.4. ХАМГААЛАХААР СОНГОСОН АМЬТНЫ ЗҮЙЛД УЧИРЧ БУЙ АЮУЛ ДАРАМТ

Аливаа экосистемийг бүрдүүлж буй биологийн олон янз байдал нь оршин тогтонохын тулд харилцан уялдаж байдаг. Үүнийг экологийн ШУ-нд зүйл хоорондын болон зүйлийн дотоод харилцаа гэж ангилан судалдаг. Хүний буруу санамсаргүй үйл ажиллагааны улмаас зарим зүйлийн амьтдын амьдрах орчин доройтож орогнох, хооллох нөхцөлгүй болох улмаар тухайн газраас дайжих, тоо толгой нь буурах үзэгдэл явагдана.

Энэхүү сэргэг үр дагавар зөвхөн тухайн амьтны хувьд зогсохгүй бөгөөд зүйл хооронд болон зүйлийн дотоод харилцаагаар дамжин системийн хүрээнд үргэлжилдэг. Үүнийг биологийн олон янз байдлын харилцааны доройтол буюу Biodiversity Net Loss гэнэ.

### Амьтдын хувьд чухал ач холбогдолтой газар нутаг

Биологийн олон янз байдлын судалгааны чухал үр дүн бол тухайн газар нутгийн чухал амьдрах орчинг тодорхойлох хэрэг юм. Чухал амьдрах орчинг тодорхойлох хэд хэдэн шалгуур үзүүлэлтүүд байдгаас бид EBRD-ийн шалгуур үзүүлэлтийг баримтлав<sup>1</sup>. Биологийн олон янз байдлын хувьд чухал буюу эмзэг амьдрах орчинг дараах үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн тусламжтай тодорхойлж болохоор байна. Үүнд:

- Биологийн олон янз байдлын хувьд баялаг газар байх
- IUCN-ийн улаан дансны шалгуураар ховордож буй төрөл зүйл амьдарч байх
- Унаган зүйл буюу хязгаарлагдмал тархацтай зүйл амьдарч байх
- Нүүдлийн зүйлүүдийн хувьд ач холбогдолтой газар байх
- Амьтны төрөл зүйл ихээр цуглардаг газар байх
- Тухайн газар нь экосистемийн орлуулашгүй үйлчилгээ үзүүлдэг байх гэх мэт.

Тухайлбал:

- Иймд бэлчээрийн зүй зохистой ашиглалтын талаар нутгийн иргэдэд сургалт хийх
- Бэлчээрийн менежментийг боловсруулах
- Байгалийн нөөцийн менежментийн сургалтыг хийх
- Нэхөрлөлийн гишүүдийг чадавхжуулах зэрэг ажлуудыг хийх нь зүйтэй байна.

### 3.5. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

Энэхүү менежментийн төлөвлөгөөний зорилго нь тогтвортой хөгжлийг хангах, удирдлага, зохион байгуулалтыг орчин үеийн шаардлагад нийцүүлэхэд чиглэгдэж доор дурдсан зорилтуудыг хангаснаар биелэгдэх болно. Үүнд :

#### Эрхэм зорилго

Эрхэм зорилго нь агнуурын зүйлүүд даацтайгаа зохицон өсч үржих нөхцлийг хангах, амьдрах орчныг нь хадгалан хамгаалах, орон нутгийн иргэдэд өгөөжтэй ашиглалтыг тогтвортой хөгжүүлэх нөхцлийг хангахад оршино.

#### Зорилго

Нутгийн иргэдийн оролцоонд түшиглэн хамтын агнуурын менежментийг хөгжүүлэх, аймгийн ан амьтны санг хамгаалах, өсгөн үржкуулэхэд чиглэгдсэн бүх үйл ажиллагааг хамарна.

#### Хамрах хүрээ

Энэхүү менежментийн төлөвлөгөө нь “Говьсүмбэр” аймгийн нутагт 2019-2023 онд хэрэгжинэ.

<sup>1</sup> [www.ebrd.com/documents/environment/performance-requirement-6.pdf](http://www.ebrd.com/documents/environment/performance-requirement-6.pdf)

**Зорилго 1. Хамгаалалтыг орон нутгийн захиргаа, иргэдтэй хамтран сайжруулах. Зорилтууд:**

1.1. Ан амьтан хамгаалах, өсгөн үржүүлэх зохистой ашиглах нөхөрлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх

1.2. Хяналтын байгууллагуудтай хамтын ажиллагааг сайжруулах

Хүрэх үр дүн : Байгаль хамгаалах ажил үр дунтэй болж, нутгийн удирдлага иргэдийн хамтын ажиллагаа сайжирна.

**Зорилго 2. Мэдээлэл түгээлт, сургалт , сурталчилгааны ажлыг сайжруулах. Зорилтууд:**

2.1. Иргэдийн дунд сургалт, сурталчилгаа зохион байгуулах

2.2. Иргэдийн байгаль орчны хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх

Хүрэх үр дүн: Нутгийн иргэдийн байгаль орчин, байгалийн баялагийн талаарх ойлголт нэмэгдэж, ан амьтнаа хайрлан хамгаалах сонирхолтой болно.

**Зорилго 3: Хяналт шалгалт, мониторингийн ажлыг сайжруулах. Зорилтууд:**

3.1. Байгаль хамгаалагчдын хариуцлагыг дээшлүүлэх, чадваржуулах

3.2. Мониторинг судалгааг тогтвортжуулах

Хүрэх үр дүн: Сумын байгаль хамгаалагчдын мэдлэг чадвар дээшлэх, тогтвортой мониторинг судалгаа хийхэд хэвшиж мэдээллийн сантай болно.

**Зорилго 4. Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах. Зорилтууд :**

4.1 Байгалийн нөөцийн мэдээллийн сантай болох (биологийн төрөл зүйл, бэлчээр, гол, булаг шанд)

4.2. Байгалийн гамшгаас сэргийлэх, эрсдэлийг бууруулах

4.3. Нөөцийн тогтвортой ашиглалтыг бий болгох

Хүрэх үр дүн: Аймгийн байгалийн баялагийн талаарх мэдээллийн сантай, биотехникийн арга хэмжээ хэрэгжин ан амьтны амьдрах орчин сайжирч тогтвортой ашиглах нөөцтэй болно.

**Зорилго 5. Хамтын оролцоотойгоор бэлчээрийн талхагдалтай тэмцэж цөлжилтийг сааруулах. Зорилтууд:**

5.1. Бэлчээрийн даацыг тогтоох

5.2. Бэлчээрийн менежментийг нэвтрүүлэх

Хүрэх үр дүн: Бэлчээрийн даац, бэлчээрийн хуваарилалт, ан амьтныг бэлчээрийн даацад нийцүүлэн өсгөн үржүүлэх боломжтой болно.

Менежментийн төлөвлөгөөний дээрх зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхдээ бүх талын хамтын оролцоонд тулгуурлан тухайн үеийн нөхцөл байдлыг харгалзан нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудаас эхлэн хэрэгжүүлж байх нь зүйтэй. Уг төлөвлөгөөний бүх үйл ажиллагаа нь дэвшиүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд оршино.

Менежментийн төлөвлөгөөний 4 дүгээр зорилго буюу байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх биотехникийн арга хэмжээний хүрээнд хужир, марааг бор гөрөөс халиун бугын тархац, байршил нутгийг харгалзан малчин өрх, малын бэлчээр нутгаас зайдуухан сонгож авах нь зүйтэй.

### 3.6. ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ/ СТРАТЕГИ.

**Стратеги 1:** Экологийн мониторингийн судалгааг удаан хугацаанд хэрэгжүүлэн, популяцид нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг судалгааны дүнг үндэслэн төлөвлөж хэрэгжүүлэх

**Стратеги 2:** Агнуурын бус нутгийг бүрэн хариуцах чадварыг хуулийн этгээдэд олгох, хуулийн этгээдтэй хамтран ажиллаж мэдлэг, туршлага эзэмшүүлэх, эрх зүйн таатай орчныг бий болгох

**Стратеги 3:** Ашиглалтаас болон бусад боломжтой бүх эх үүсвэрээс тогтвортой санхүүжилтээр хангах

**Стратеги 4:** Ан амьтны гаралтай хууль бус үйлдлийг бууруулах,

**Стратеги 5:** Байгаль орчны газрын мэргэжилтнүүд төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт мониторинг хийх чадвар эзэмшүүлэх,

3.7. 2019-2023 СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ

*Хүснэгт 10. Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө*

Үйл ажиллагаа	Хугацаа ба төсөв(мян.төг)	Нийт төсөв	Гүйцэтгэх байгууллага	Үр дүн, баталгаа
<b>Зорилго 1. Хамгаалалтыг орон нутгийн захиргаа, иргэдтэй хамтран сайжруулах</b>				
1.3. Зорилт 1.1. Ан амьтан хамгаалах, ёсгэн үржүүлэх зохистой ашиглах нөхөрлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх				
1.3.1. Ан амьтныг хамгаалах нөхөрлөлүүдийг аймгийн хэмжээнд бүртгэлжүүлэх	1 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,		Нөхөрлөлүүд бүртгэгдэж, ажиллах журам боловсрогдон, сургалт зохион байгуулагдсан байна.
1.3.2. Нөхөрлөлийн гишүүдэд ан амьтны нөөцийг хамгаалах, ашиглах сургалтыг зохион байгуулах	3 сая	Аймгийн БОАЖГ		
1.3.3. Нөхөрлөлийн ажиллах журмыг боловсруулан мөрдөх	1 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,		
1.3.4. Нөхөрлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүр төлөвлөж хэрэгжүүлэх	2 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,		Хамтран боловсруулсан төлөвлөгөө, жилийн ажлын тайлан
1.3.5. Төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх	1 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,		Төлөвлөгөөний биелэлтийг үнэлсэн хэлэлцүүлгийн протокол, тайлан
1.3.6. Нөхөрлөлийг байгалийн нөөцийн менежмент, хамтын оролцооны чиглэлээр чадваржуулах	3 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,		Сургалт зохион байгуулсан тайлан, холбогдох зураг, бичлэг, байгуулагдсан гэрээ
1.3.7. Байгаль хамгаалах иргэдийн нөхөрлөлүүдтэй байгаль хамгааллын төлөвлөгөө гарган хамтын ажиллагааны урт хугацааны гэрээ байгуулах, урамшуулах	2 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,		

Үйл ажиллагаа	Хугацаа ба төсөв(мян.төг)	Нийт төсөв	Гүйцэтгэх байгууллага	Үр дүн, баталгаа
	2019-2023 он			

Зорилт 1.2. Хамтын ажиллагааг бүх шатанд өргөжүүлэх замаар хяналт, хамгаалалтын үр нэлөөг дээшлүүлэх				
1.2.1. Талуудын хамтран ажиллах нөхцөл, Үүрэг хариуцлагыг харилцан тохиролцон гэрээ байгуулах	3 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ, Ан Агнуурын үйл ажиллагаа эрхэлдэг ААН-ҮҮД	Гэрээг дүгнэсэн хурлын тэмдэглэл	
1.2.2. Байгаль хамгаалагч, идэвхтэн байгаль хамгаалагчийг техник хэрэгсэл, хувцас форм, унаа, урсгал зардлаар үе шаттай хангах, (нөхөрлөлд мотоцикл, дуран, зургийн аппрад, gps)	10 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,	Тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал	
1.2.3. Нөхөрлөлийн төлөөллүүд, идэвхтэн байгаль хамгаалагчдаас сонгон хяналт, шалгалтын баг бүрдүүлэн ажиллах,	2 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,	Байгуулагдсан баг, гарсан үр дүн	
1.2.4. Ан амьтан хамгаалахад идэвхи санаачлагатай ажиллаж байгаа иргэдэд, идэвхтэн байгаль хамгаалагчдад урамшуулал олгох	5 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,	Үр дүнг дүгнэсэн гэрээ	
Хүрэх үр дүн	Байгаль хамгаалах ажил үр дүнд хүрч, нутгийн удирдлага, иргэдийн хамтын ажиллагаа сайжирна.			
Зардлын дүн	30.000.000₮			

Үйл ажиллагаа	Хугацаа ба төсөв(мян.төг) 2019-2023 он	Нийт төсөв	Гүйцэтгэх байгууллага	Үр дүн, баталгаа
Зорилго 2. Мэдээлэл түгээлт, сургалт, сурталчилгааны ажлыг сайжруулах				
Зорилт 2.1. Иргэдийн дунд сургалт сурталчилгаа зохион байгуулах				
2.1.1. Иргэдийн дунд байгалийн баялгийг зохистой ашиглах, хамгааллын ач холбогдлыг сурталчлах ажлыг зохион байгуулах	5 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,	Сургалт зохион байгуулсан тайлан зураг,	
2.1.2. Иргэдийн дунд байгаль орчны нөхөрлөлийн талаар сургалт зохион байгуулах	2 сая	Аймгийн БОАЖГ, Агнуур бус нутаг хариуцдаг аж ахуйн нэгжүүд	бичлэг, оролцогчдын үнэлгээ	
Зорилт 2.2. Иргэдийн байгаль орчны болон хууль зүйн мэдлэгийг дээшлүүлэх				
2.2.1. Агнуурын бус нутгийн дэглэм, хууль эрх зүйн үндэс, хилийн заагийг танилцуулах	1 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,	Сурталчилгаа-ны материал хилийн цэсийн зураг	

## ГОВЬСУМБЭР АЙМГИЙН АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ

2.2.1. Бусад газар (ТХГН)-т байгуулагдсан байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн сайн үйл ажиллагаа туршлагыг судлан нэвтрүүлэх	2 сая	Аймгийн БОАЖГ,	Бусад нөхөрлөлийн үйл ажиллагаа, туршлагын талаарх танилцуулга материал, бичлэг тайлан
2.2.2. Нөхөрлөлийн хариуцан хамгаалах нутгийн ан амьтдыг хамгаалах, зохистой ашиглах арга хэмжээг тодорхойлох, судалгааны арга зүйн сургалт зохион байгуулах	2 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,	Сургалтын материал, тайлан, зураг, бичлэг
2.2.3. Агнуурын бүс нутгийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд танилцуулах, сурталчилгааны материал хэвлэх түгээх зэрэг бусад арга хэмжээг зохион байгуулах	2 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, гарсан үр дүн
Үйл ажиллагаа	Хугацаа ба төсөв(мян.төг) 2020-2022 он	Нийт төсөв	Гүйцэтгэх байгууллага
Хүрэх үр дүн	Нутгийн иргэдийн байгаль орчин, байгалийн баялагийн талаарх ойлголт нэмэгдэж, ан амьтнаа хайрлан хамгаалах сонирхолтой болно		
Зардлын дүн	14.000.000₮		

Үйл ажиллагаа	Хугацаа ба төсөв(мян.төг) 2019-2023 он	Нийт төсөв	Гүйцэтгэх байгууллага	Үр дүн, баталгаа
<b>Зорилго 3. Хяналт шалгалт, мониторингийн ажлыг сайжруулах</b>				
<b>Зорилт 3.1. Байгаль хамгаалагчдын хариуцлагыг дээшлүүлэх, чадваржуулах</b>				
3.1.1. Идэвхтэн байгаль хамгаалагчдыг сонгон гэрээ байгуулж, үнэмлэх олгох	-	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,	Идэвхтэн байгаль хамгаалагч-тай хийсэн гэрээ	
3.1.2. Байгаль хамгаалагчдыг батлагдсан хөтөлбөрийн дагуу үе шаттайгаар сургах	2 сая	Аймгийн БОАЖГ	Сургалтын хөтөлбөр, оролцогч-дын тоо, тайлан	
3.1.3. Байгаль хамгаалагчдын ажлыг хууль бус ан агнуурыг илрүүсэн үр дүнгээр урамшуулах	2 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,	Үнэлгээний аргачлал, дүн	
<b>Зорилт 3.2. Мониторинг судалгааг тогтвортжуулах</b>				

## ГОВЬСУМБЭР АЙМГИЙН АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ

3.2.1 Мониторинг судалгаа хэрэгжүүлэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, урсгал зардлаар хангах	3 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,	Судалгааны сар бүрийн тайлан
3.2.2. Ан амьтны байршил нутгуудад хийх судалгааны хэрэгцээг тодорхойлон, мониторингийн судалгааны чиглэл бүрээр төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	-	Аймгийн БОАЖГ	Хэрэгжсэн төсөл хөтөлбөр, хяналт шалгалтын илрүүсэн үр дүнгүүд
3.2.4. Агнуурын зүйлүүдийн үржих, төллөх, үр төлөө өсгөх байршил нутагт хяналтыг эрчимжүүлэх	3 сая	Аймгийн БОАЖГ	Хууль бус ан агнуур ба бэлчээрийн зохисгүй ашиглалтыг бууруулах
3.2.5. Эрх зүйн орчинг сайжруулахтай холбоотой саналуудыг уламжлах	-	Аймгийн БОАЖГ	Уламжилсан санал
3.2.6. Шаардлагатай газар хяналтын камер суурилуулах	2 сая	Аймгийн БОАЖГ,	Зураг, бичлэг, тайлан
Хүрэх үр дүн	Байгаль хамгаалагчдын мэдлэг чадвар дээшлэх, тогтвортой мониторинг судалгаа хэвшиж мэдээллийн сантай болно.		
Зардлын дүн	12.000.000₮		

Үйл ажиллагаа	Хугацаа ба төсөв(мян.төг) 2019-2023 он	Нийт төсөв	Гүйцэтгэх байгууллага	Үр дүн, баталгаа
<b>Зорилго 4. Байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах</b>				
<b>Зорилт 4.1. Байгалийн нөөцийн мэдээллийн сантай болох(биологийн төрөл зүйл, бэлчээр, гол, булаг, шанд )</b>				
2.1.1. Агнуурын бүс нутгийн амьтдын танилцуулга, боршур хийж нутгийн иргэдэд тараах	1 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,		
2.1.2. Гол мөрөн, булаг шандын судалгааг гаргаж, сэргээх, хамгаалах арга хэмжээг тогтоох	2 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,		Мэдээллийн сантай болсон байна.
2.1.3. Биотехникийн арга хэмжээг зохион байгуулах	10 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ, Агнуурын бүс нутаг хариуцдаг аж ахуйн нэгжүүд		Биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлсэн тайлан

## ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1.4. Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн тооцоог тодотгон боловсруулах	-	Аймгийн БОАЖГ	Батлагдсан төсөв
<b>Зорилт 4.2. Байгалийн гамшгаас сэргийлэх, эрсдэлийг бууруулах</b>			
4.2.1. Ган зудтай үед хэрэглэх хадлан, тэжээл, хужир, давс бэлтгэн нөөцлөх	8 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,	Нөөцөлсөн өвс, тэжээл, давс хужирын хэмжээ
1.1.1. Суурьшлын бүсрүү нэвтэрсэн зэрлэг амьтдыг авран хамгаалах ажлыг зохион байгуулах (Унтуулах буу, сум, тээвэрлэх машин, тор, мэргэжлийн боловсон хүчин, баг бүрдүүлэх)	15 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,	Зэрлэг ан амьтдыг авран хамгаалах зорилгоор авсан арга хэмжээ, тоног төхөөрөмжийн тоо хэмжээ
<b>Зорилт 4.3. Нөөцийн тогтвортой ашиглалтыг бий болгох</b>			
4.3.1. Жил бүр аймгийн хэмжээнд агнагдах ан амьтны тоог сумдаас ирсэн хүсэлтийг үндэслэн БОАЖЯаманд уламжлах	-	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,	Төрийн захиргааны төв байгууллагад илгээсэн албан бичиг
4.3.2. Тусгай зориулалтын агнуурыг гадаадын анчдад зуучлагч ААН-үүдтэй хамтарсан уулзалт хийх	1 сая	Аймгийн БОАЖГ	Оролцсон бичлэг, зураг, тайлан
4.3.3. БОАЖЯ, аж ахуйн нэгж, байгууллагын зуучлал дэмжлэгээр төлөөлөгчөө ангийн бүтээгдэхүүн борлуулах үзэсгэлэнгүүдэд оролцож туршлага судлах	2 сая	Аймгийн БОАЖГ	
Хүрэх үр дүн	Аймгийн хэмжээнд байгалийн баялгийн талаарх мэдээллийн сантай, биотехникийн арга хэмжээ хэрэгжин ан амьтны амьдрах орчин сайжирч тогтвортой ашиглах нөөцтэй болно.		
Зардлын дүн	37.000.000₮		

Үйл ажиллагаа	Хугацаа ба төсөв(мян.төг)	Нийт төсөв	Гүйцэтгэх байгууллага	Үр дүн, баталгаа			
	2019-2023 он						
Зорилго 5. Хамтын оролцоотойгоор бэлчээрийн талхагдалтай тэмцэж цөлжилтийг сааруулах							
<b>Зорилт 5.1. Бэлчээрийн даацыг тогтоох</b>							
5.1.1. Бэлчээрийн нөөц ашиглалтын үнэлгээг хийх	5 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ, Мэргэжлийн байгууллага					

5.1.2. Малчдын өвөлжөө, хаваржааны байршил, малын төрөл, тоо толгой, эзэмшлийн судалгааг гаргах	1 сая	Сумын ЗДТГ, Аймгийн Байгаль орчны газар	Судалгааны тайлан
5.1.3. Улирлын бэлчээрийн хуваарийг малын тоо толгойд зохицуулан гаргах	2 сая	Сумын ЗДТГ,	Бэлчээрийн даацаад тохирсон улирлын хуваарь
<b>Зорилт 5.2. Бэлчээрийн менежментийг нэвтрүүлэх</b>			
5.2.1. Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх	2 сая	Аймгийн БОАЖГ, Сумдын ЗДТГ,	Батлагдсан бэлчээрийн менежментийн төлөвлөгөө
5.2.2. Бэлчээрийн даацыг одоо байгаа түвшинээс үе шаттайгаар бууруулах, - Улирлын бэлчээрт сэлгээ нэвтрүүлэх, - Бэлчээр ашиглалтыг сайжруулж, ашиглалтгүй бэлчээрийн шалтгааныг тодорхойлох, ашиглах - Хадлан, бэлчээрийг бордох, дэрс шатаах залуужуулах зэрэг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	-	- Мал зүйч - Бэлчээр тэжээлийн мэргэжилтэн - Сумын газар зохион байгуулагч - Бүх шатны дарга нар	- Бэлчээрийн бүтээмж дээшилж нэг малаас авах ашиг шим нэмэгдэнэ. - Бэлчээрийн ургамал байгалийн аясаар нөхөн төлжих нөхцөл бүрдэнэ. - Нэгж талбайн ургац нэмэгдэх, ургамалан нөмрөг сайжирч цөлжилтийг бууруулах
Хүрэх үр дүн	Бэлчээрийн даац, бэлчээрийн хуваарилалт, ан амьтныг бэлчээрийн даацаад нийцүүлэн өсгөн үржүүлэх боломжтой болно.		
Зардлын дүн	10.000.000₮		
Нийт төсөв	103.000.000₮		

Тайлбар: “+” тэмдэгээр төсөв шаардагдахгүй хэрэгжүүлэх боломжтой эсвэл үйл ажиллагааны явцад зохицуулж болох арга хэмжээг тэмдээлэв.

Менежментийн төлөвлөгөөний дээрх зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхдээ бүх талын хамтын оролцоонд тулгуурлан тухайн үеийн нөхцөл байдлыг харгалзан нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудаас эхлэн хэрэгжүүлж байх нь зүйтэй. Уг төлөвлөгөөний бүх үйл ажиллагаа нь дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд оршин

ДӨРӨВДҮГЭЭРБҮЛЭГ. МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ, МОНИТОРИНГ

4.1. АМЬТНЫГ ХАМГААЛАХ, НӨӨЦИЙГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН БҮТЭЦ

Схем 3. Амьтныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах үйл ажиллагааны удирдлагын бүтэц



**Санхүүгийн эх үүсвэр:** Менежментийн төлөвлөгөөнд тавигдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд нийт 103 сая төгрөг шаардагдах тооцоо гарч байна.

- Талуудыг чадавхижуулах, удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаанд
- Судалгаа мониторингийн төлбөрийг хэрэгжүүлэхэд
- Сургалт, сурталчилгаа, хяналтын үйл ажиллагаанд

**Хэрэгжүүлэх байгууллага :** Ан агнуурын менежментийг аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газар хэрэгжүүлнэ.

**Санхүүжилт :** Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу тусгай зориулалтаар агнаж, барьсан ан амьтны төлбөрийн орлогын 50-аас доошгүй хувийг агнуурын бус нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулна. Үндсэн санхүүжилт нь агнуураас орох орлого боловч бусад эх үүсвэрээс (хариуцагч компанийн тусламж, хандив, өөрийн орлого г.м) дэмжлэг авч болно.

Энэхүү менежментийн төлөвлөгөөний зорилго, түүнд тусгагдсан үйл ажиллагаануудыг илүү тодорхой болгон нарийвчилж тусгах шаардлагатай. Менежментийн төлөвлөгөө хэрэгжих

хугацаанд төр, засгийн газрын бодлогод орох өөрчлөлтүүдтэй уялдан шаардлагатай үед нэмэлт өөрчлөлт хийж болно.

#### 4.2. ОРОН НУТГИЙН ИРГЭДЭД ТУШИГЛЭСЭН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Орон нутгийн иргэдэд тушиглэсэн ан амьтныг хамгаалах хамтын менежментэд нутгийн иргэдийг бэлтгэх, тухайлбал, хөдөлмөрөө хоршиж хоршоо, хамтлаг, нөхөрлөл байгуулах замаар орон нутгийн засаг захиргаатай хамтран ан амьтны нөөцийг ашиглах, ан агнуурын холбогдолтой гарсан зөрчлийг шийдэх энгийн хэлбэр бүтцийг бий болгох эрх зүй, эдийн засгийн орчинг бүрдүүлэх явдал юм.

“Амьтны тухай хууль”-ийн 24.3 дугаар зүйлд агнуурын амьтныг үйлдвэрлэлийн, ахуйн, тусгай зориулалтаар агнаж барихаар хуульчлан тогтоожээ. Иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл тус тус авч, үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад гэрээ байгуулна.

Өнөөдрийн байдлаар дээрх 3 зориулалтын ан агнуурыг зохион байгуулж байгаа тогтолцоонд үндсэн 2 үе шат тод харагдаж байна.

1-р үе шат : Агнуурын үйл ажиллагаанд бэлтгэх

1. Ахуйн болон үйлдвэрлэлийн агнуурын амьтдыг ашиглах зөвшөөрлийг хуваарилах механизм
  - 1.1. Тухайн амьтны үржил, нөхөн үржих процесцд сөрөг нөлөө үзүүлэхгүй бусад хуулийг зөрчихгүй байх үндэслэлээр агнуурын бүс нутгийн хил хязгаарыг тодорхой цаг хугацаатайгаар тогтоож, баримтлах дүрэм, журмыг баг, сумын түвшинд иргэдтэй хамтран боловсруулах
  - 1.2. Амьтны тухай хуулийн 3.3 дугаар заалт (сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал агнуурын амьтны байршил нутагт үйлдвэрлэлийн, ахуйн болон тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих бүс тогтоож болно гэж заажээ)-д тусгасны дагуу дээрх дүрэм журмыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталгаажуулах
  - 1.3. Агнуурын бүс нутаг дахь агнуур зохион байгуулалтыг иргэд, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хуулинд заасан хугацаанд зохион байгуулах
  - 1.4. Агнуурын амьтдын нөөцийг зохистой ашиглах, хамгаалах менежментийн төлөвлөгөө боловсруулах, агнуурын амьтдын нөөцийг тогтоох
  - 1.5. Агнуурын бүс нутаг, агнуурын менежмент, агнуур зохион байгуулалтын тайланг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж баталгаажуулах
  - 1.6. Аймгийн ИТХ нь агнуурын бүс нутаг, менежмент төлөвлөгөө, агнуур зохион байгуулалтыг үндэслэн хуваарилалтыг суманд хийх
  - 1.7. Сумын ИТХ нь хуваарилалтыг Байгаль орчны тухай хуулийн 3-р зүйлийн 2-р хэсгийн 8 дахь заалтад заасны дагуу нөхөрлөл байгуулан оршин суугаа нутгийнхаа

тодорхой төрлийн ан амьтныг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр ашиглах, эзэмших асуудлыг гэрээний дагуу хуваарилах

**2. Тусгай зөвшөөрлийн агнуурын амьтан агнах зөвшөөрөл олгох**

Байгаль орчны сайдын 2013 оны 93 дугаар тушаалаар баталсан “Ховор амьтан агнах, барих зөвшөөрөл олгох журам”-ын хавсралтад: Тусгай зориулалтын ан амьтан агнах, барих зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тухайн сумын засаг даргын албан бичгээр тус тус олгоно гэж тогтоосныг үндэслэн:

- 2.1. Тусгай зөвшөөрлийн агнуурын амьтны бүс нутгийг тухайн сумын ИТХТ-ээр хэлэлцэж тогтоох
- 2.2. Тусгай зөвшөөрлийн агнуурын амьтдын нөөцийг иргэдийн нөхөрлөлийн оролцоотой мэргэжлийн байгууллагаар тогтоох
- 2.3. Тусгай зөвшөөрлийн агнуурын амьтдыг зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагааг энэ журмын 1.4-д заасан агнуурын мененжментэд тусгасан байх
- 2.4. Тухайн жилд агнах тусгай зөвшөөрлийн дээд хязгаарыг аймгийн ИТХ энэ журмын 1.1, 1.2, 1.3 -т заасан баримт бичгийг үндэслэн тогтооно.
- 2.5. Тухайн жилд нутаг дэвсгэртээ агнуулах тусгай зөвшөөрлийн ангийн тоо хэмжээний саналыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх
- 2.6. Байгаль орчин, аялал жуулчлалын яам “Ховор амьтан агнах, барих зөвшөөрөл олгох журам”-ын дагуу тухайн сумын Засаг даргын албан бичгийг үндэслэн зөвшөөрлийг олгоно.

**3. Ан агнуур эрхлэх аж ахуй нэгжид тавигдах шаардлага**

- 3.1. Ан агнуурын жуулчлал эрхэлж байсан ажлын дадлага, туршлага бүхий мэргэжлийн боловсон хүчин, материаллаг бааз, хөрөнгийг чадавхитай байх
- 3.2. Гадаад харилцаа, дараа онд хийхээр төлөвлөсөн ангийн урьдчилсан гэрээ, хэлцэлтэй байх
- 3.3. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх талаар тодорхой хийж гүйцэтгэсэн ажилтай байх
- 3.4. Эрх авсан аж ахуйн нэгж байгууллагын хувьд хуваарын ангаа бүрэн борлуулсан, ангийн болон төлбөр, хураамжийн тооцоог хугацаанд нь хийж гүйцэтгэсэн байх
- 3.5. Ангийн олзворын болон ан амьтныг гадаадад гаргах үнийн зах зээлийн судалгаанд үндэслэгдсэн ангийн олзворын үнийн зөв бодлого явуулах менежментийг бүрдүүлсэн байх

**2-р үе шат. Агнуурын үйл ажиллагааг зохион байгуулах**

Ахуйн болон үйлдвэрлэлийн агнуурыг зохион байгуулах

1. Байгаль хамгаалах хуулийн этгээд, иргэдийн бүлэг, нөхөрлөл сумын Засаг даргатай хийсэн гэрээний дагуу агнуурын бүс нутагтаа агнуурын үйл ажиллагааг зохион байгуулах
2. Сумын байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч нар агнуурын үйл ажиллагаанд хяналт тавих
3. Агнуурын бүтээгдэхүүний борлуулалтаас орлогын 10-аас доошгүй хувийг дундын санд төвлөрүүлэх
4. Агнуурын үйл ажиллагааны тайланг сумын ИТХ-д оруулж хэлэлцүүлэх

## 5. Аймгийн ИТХ-д танилцуулах

Тусгай зөвшөөрлийн агнуурыг зохион байгуулах

1. Тусгай зөвшөөрөл авсан компани 2.10-т заасан гурвалсан гэрээний дагуу агнуурыг агнуурын бүс нутагт зохион байгуулах
2. Агнуур зохион байгуулсан гэрээний биелэлтийг 3 тал хамтран хэлэлцэж, дүгнэх
3. Дээрх дүгнэлтийг сумын ЗДТГ-т хүргүүлж сумын ИТХ-аар хэлэлцүүлэх
4. Сумын ИТХ-аар хэлэлцсэн дүнг аймгийн ИТХ-д танилцуулах, тайланг хүргүүлэх

## 4.3. ҮНЭЛГЭЭ, МОНИТОРИНГ

Менежментийн төлөвлөгөөнд хяналт мониторинг хийх чиглэлийг доорх байдлаар тодорхойлж байна. Үүнд :

1. Нөхөрлөл хэрхэн чадавхижсан, хамгаалалтын ажилд хэр зэрэг идэвхитэй оролцож байгаад,
2. Агнуурын зүйлүүдийн нөөц, амьдрах орчны байдал, тэдгээрийн хамгаалалтын чадавхид гарсан өөрчлөлт нь менежментийн төлөвлөгөөний зорилтыг ханган биелүүлэх шаардлагын хэмжээнд хүрч байгаа эсэхэд,
3. Агнуур нь тавигдаж буй шаардлага, зарчимд хэр зэрэг нийцтэй болсон, байгальд болон нутгийн иргэдийн амьжиргаанд хэрхэн нөлөөлж байгаад,
4. Орон нутгийн удирдлага, нөхөрлөлийн гишүүдийг байгаль хамгаалах хууль, тогтоомж, экологийн мэдлэг олгох сургалтанд хэрхэн хамруулсан, энэ нь үр дүнд хүрч байгаа эсэхэд,
5. Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр тухайн бүс нутгийн агнуурын амьтны популяци, амьдрах орчинд өөрчлөлт гарсан эсэх зэрэгт чиглэсэн мониторинг хийх,
6. Аймгийн БОАЖГ-аас жил бүр менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад мониторинг ба үнэлгээ жил бүр хийж байх.
7. Менежментийн төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэх явцад зөрчил, доголдол илрэх нь мэдээж бөгөөд үүнд зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэр гарган засаж запруулах, хариуцаж буй байгууллага, албан тушаалтанд арга хэмжээ авах, урамшуулах зэрэг хариуцлагын механизм шударга үйлчлэх ёстай.

Энэхүү хуулийн дагуу авсан арга хэмжээ нь талууд, оролцогчдод жигд үйлчлэх ба бусдад үр нөлөө өгөхүйц байх хэрэгтэй.

Менежментийн төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний үр дүнг дараах шалгуураар үнэлж дүгнэж болно. Үүнд :

1. Байгаль орчны газрын үйл ажиллагааны арга барил, цар хүрээнд гарсан өөрчлөлт, багаар ажилласан чадварын үзүүлэлт,
2. Оролцогч талуудтай хамтын ажиллагаанд гарсан өөрчлөлт, дэмжигчдийн хүрээ өргөжсөн үзүүлэлт,
3. Ан амьтны тоо, толгойн ба ба тархац даацаа хүртэл өссөн буюу түүний тогтвортой байдал хэрхэн хадгалагдаж байгаа, мөн амьдрах орчны үзүүлэлтүүд,
4. Нөхөрлөлүүд мэргэжлийн боловсон хүчинээр хангагдсан байдал,

5. Ан амьтан хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагчид, нөхөрлөлийн гишүүд ажил үүргээ хэрхэн биелүүлж байгаад үнэлэлт дүгнэлт өгөх, улмаар урамшуулах, шагнах, хариуцлага тооцож байх нэгдсэн механизм бүрэлдэн тогтсон байх,
6. Холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, экологийн мэдлэг олгох, талуудын оролцогчдыг сургах, хяналт шалгалт хийх зохиох байгуулалтын оновчтой тогтолцоо буй болж төлөвшсөн байх,

Хяналт мониторингийг төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, хяналтын байгууллагууд өөрсдийн эрх мэдлийн хүрээнд төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж болно.

### ХАВСРАЛТУУД НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- “Агнуурын бүс нутаг” гэж агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах зориулалт бүхий ан амьтны байршил, тархац нутгийг; (“Амьтны тухай” хууль, 4.1.9.)
- “Агнуурын амьтны сан” гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дэх унаган, нутагшсан буюу нүүдлийн агнуурын хөхтөн амьтан, шувуу, загаснаас бүрдэнэ. (“Амьтны тухай” хууль, 2.2.1.)
- “Ан агнуурын менежментийн төлөвлөгөө” гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичгийг; (“Амьтны тухай” хууль, 4.1.11.)
- “Агнуурын амьтан” гэж арьс, үс, мах болон бусад түүхий эдийг нь ашиглахаар агнаж ирсэн уламжлалтай, агнуурын нөөцтэй амьтныг, (“Амьтны тухай” хууль, 4.1.7)
- “Агнуурын нөөц” гэж агнуурын амьтны биологийн нөөцөөс хэвийн өсөлт, үржилтийг алдагдуулахгүй агнах, барих боломжтой тоо хэмжээ (Амьтны тухай” хууль, 4.1.8)
- “Трофейн буюу олзворын ан” ан амьтны илүү үзүүлэлт бүхий эд, эрхтнийг авах зорилгоор тусгай төлбөр төлж агнах, барих үйлийг (“Амьтны тухай” хууль, 4.1.16);
- “Спорт ан” гэж анчин ан агнах, барих хэрэгцээгээ хангах зорилгоор ан амьтны эд, эрхтнийг үзүүлэлтийн хувьд сонголт болголгүй агнах, барих үйлийг (“Амьтны тухай” хууль, 4.1.15);

**Товчилсон үгийн тайлбар**

- |        |  |
|--------|--|
| АБН    | - Агнуурын бус нутаг                               |
| АЗБ    | - Агнуур зохион байгуулалт                         |
| БОАЖЯ  | - Байгаль орчин, аялал жуулчлалын яам              |
| БОАЖГ  | - Байгаль орчин, аялал жуулчлалын газар            |
| ДБХС   | - Дэлхийн байгаль хамгаалах сан                    |
| НИТААМ | - Нутгийн иргэдэд түшиглэсэн ан агнуурын менежмент |
| ОНТХГ  | - Орон нутгийн тусгай хамгаалалттай газар          |
| ТЗТБ   | - Төрийн захиргааны төв байгууллага                |
| НҮТББ  | - Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага         |

ХАВСРАЛТ

